



“УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР”



2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот

2024.12.27

АГУУЛГА

1.	Төсөл, арга хэмжээний нэр:	4
2.	Хөгжлийн түнш/ санхүүжүүлэгч байгууллага	4
3.	Төсөл, арга хэмжээний зорилго.....	4
4.	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	5
5.	Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр	5
6.	Тайлан хугацаанд гарсан ашиглалт, санхүүжилт	6
7.	Төсөл, арга хэмжээний нийт ашиглалт.....	6
8.	Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хувь хэмжээ:	7
9.	Тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн томоохон ажлууд:	9
9.1.	ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ	9
9.1.1.	Хөтөлбөрийн хоёр дугаар үе шат	14
9.1.1.1.	Товч танилцуулга	14
9.1.1.2.	Худалдан авах ажиллагааны явц	15
9.1.1.3.	Барилгын ажлын явц	18
9.1.1.4.	АХБ-ны хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх	24
9.1.1.5.	Санхүүжилт	31
9.1.2.	Хөтөлбөрийн гурав дугаар үе шат	32
9.1.2.1.	Товч танилцуулга	32
9.1.2.2.	Худалдан авах ажиллагааны явц	33
9.1.2.3.	Барилгын ажлын явц	35
9.1.2.4.	АХБ-ны хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх.....	38
9.1.2.5.	Санхүүжилт.....	46
10.	Цаашид хийхээр төлөвлөсөн ажлууд.....	46
11.	Тулгамдаж буй асуудлууд	46
12.	Шийдвэрлэх арга зам, авч хэрэгжүүлэх арга хэмжээ.....	47
13.	Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл:	47
13.1.	Хөтөлбөрийн үйл ажиллагааны ил тод байдал	47
13.2.	Өргөдөл гомдлыг хүлээж авах шийдвэрлэх үйл ажиллагаа	48
13.3.	Хөтөлбөрийн хүрээнд дагаж мөрдөж буй бодлогын баримт бичгүүд.....	48



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АХБ	Азийн хөгжлийн банк
ЕХОБ	Европын хөрөнгө оруулалтын банк
НЗДТГ	Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар
ХАА	худалдан авах ажиллагаа
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТУХ	Төслийн удирдах хороо
УБГХХХОДХ	Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр
ГЧНШ	газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлт
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
СБД	Сүхбаатар дүүрэг
УСУГ	Ус Сувгийн Удирдах Газар
НОСК	Нийслэлийн орон сууцны корпораци
НОСБГ	Нийслэлийн орон сууцны бодлогын газар


1. **Төсөл, арга хэмжээний нэр:** Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр (MFF-0078)
2. **Хөгжлийн түнш/ санхүүжүүлэгч байгууллага:** Азийн хөгжлийн банк (АХБ), Европын хөрөнгө оруулалтын банк (ЕХОБ), Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар (НЗДТГ)
3. **Төсөл, арга хэмжээний зорилго:** Гэр хорооллын бүсэд нийгмийн болон инженерийн дэд бүтцийг цогцоор барьж байгуулснаар Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хот болгон хөгжүүлэх суурь нөхцөлийг бий болгоход оршино.

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийг “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” бодлогын баримт бичигт заасан эдийн засгийн боломж, орон сууц, хотын дэд бүтцийн үйлчилгээ хангамж бүхий эрүүл, аюулгүй, тав тухтай амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлсэн, бие даан хөгжсөн дэд төвийн сүлжээг гэр хороололд бий болгох зорилт дэвшүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Мөн хөтөлбөрийг Баянхошуу, Сэлбэ, Дамбадаржаа, Дэнжийн мянга, Толгойт болон Шархад дэд төвүүдийн бүтээн байгуулалтын ажлыг бүрэн хэрэгжүүлэх зорилготойгоор урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгасан учир доорхи бичмг баримтуултай уялдуулан хэрэгжүүлж байна. Үүнд:

- Алсын хараа – 2050
 - 9.1.18 Хотын хэмжээнд бүх насны иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, биеийн тамир спортын барилга байгууламжийг төлөвлөн байгуулна
 - 9.3.2 Соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв, төрөлжсөн төв, олон нийтийн төвүүдийг шинээр байгуулж, хот доторх төвлөрлийг багасгана
 - 9.3.37 Нийслэлийн алслагдсан бүсүүдэд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий оргил ачааллын үед ажиллах хэсэгчилсэн, бие даасан дулааны эх үүсвэрүүдийг барьж байгуулан төвлөрсөн дулаан хангамжийн системд холбож, үр ашгийг дээшлүүлнэ
 - 9.3.46 Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу нийслэл болон дагуул, хаяа хот, тосгоны инженерийн дэд бүтцийг үе шаттай барьж байгуулан өргөтгөж шинэчилнэ
- Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
 - 9.3.1.соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв баригдаж төвлөрлийг бууруулна
 - 9.3.3.инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ технологийг нэвтрүүлнэ
- Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө
 - 6.2.2.2. Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн хоёр дугаар үе шатыг хэрэгжүүлэх
 - 6.2.2.3. Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн гуравдугаар үе шатыг хэрэгжүүлэх
- Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
 - 1.1.3.1 Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу дэд төв орчмын газрыг үргэлжлүүлэн чөлөөлж, нийгмийн болон инженерийн дэд бүтцийг барих, 20,000 айлыг орон сууцжуулах үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн

- түншлэлээр хэрэгжүүлж, Толгойт, Шархад, Дэнжийн 1000, Дамбадаржаа, Яармаг дэд төвүүдийн инженерийн дэд бүтцийг барьж байгуулна
- “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр
 - 4.2.1. Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор дэд төвүүдийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, суурь дэд бүтцийг барьж байгуулах
 - Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
 - 9.2.2 "Баянхошуу", "Сэлбэ", "Дамбадаржаа", "Дэнжийн 1000", "Толгойт", "Шархад" дэд төвүүдийг байгуулна.
 - 9.13.1 Мэдээлэл, холбооны нэгдсэн төвийн барилга, худаг сувагчлалын байгууламж шинээр барьж, мэдээлэл холбооны нэгдсэн сүлжээ бий болгосон байна.
 - Нийслэлийн засаг даргын бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
 - 2.2.3.3. Нийслэлийн дэд төвүүдэд биеийн тамир спортын барилга байгууламж, төрөлжсөн задгай талбайг төлөвлөх, барих асуудлаар хлбогдох байгууллагуудтай хамтран ажиллана
 - 2.7.1.6. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төв байгуулсан байна.
 - 6.1.2.2. Баянхошуу, Сэлбэ, Дамбадаржаа, Дэнжийн мянга, Толгойт, Шархад дэд төвүүдийн бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгана
 - 6.3.34.1. Мэдээлэл холбооны төв шинээр барина
 - 6.3.34.2. Сувагчлалын байгууламж шинээр барина
4. **Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:** Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар
5. **Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр:** АХБ-ны хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж, ЕХОБ-ны хөнгөлөлттэй зээл болон НЗДТГ-ын санхүүжилт



Зураг 1 Хөтөлбөрийн санхүүжилт

(сая. ам доллараар)

Эх үүсвэр	Хөтөлбөр	I үе шат	II үе шат	III үе шат
АХБ-ны санхүүжилт	163.70	53.70	66.35	43.65
(COL)	70.34	22.50	29.24	18.60
(OCR)	89.66	27.50	37.11	25.05
МОН-0380	3.70	3.70	-	-
НЗДТГ-ын төсөв	89.01	33.15	40.65	15.21
ЕХОБ-ны санхүүжилт	60.32	22.01	19.44	18.87
Нийт	313.03	108.86	126.44	77.73

Хүснэгт 1. Санхүүжилтийн эх үүсвэр

6. Тайлан хугацаанд гарсан ашиглалт, санхүүжилт:

2024 оны Улсын төсөв

(төгрөгөөр)

д/д	Төслийн нэр	Санхүүжилтийн эх үүсвэр	Төсөв	Гүйцэтгэл	%
1	I дүгээр үе шат	ЕХОБ 83097	3,900,000,000.00	3,776,272,571.16	96.83%
Нийт			3,900,000,000.00	3,776,272,571.16	96.83%
1	II дугаар үе шат	MON-3525 OCR	24,117,600,000.00	24,117,545,813.86	100.00%
2		MON-3526 COL	12,450,000,000.00	12,442,838,265.40	99.94%
3		ЕХОБ 83873	16,165,000,000.00	16,161,384,997.48	99.98%
Нийт			52,732,600,000.00	52,721,769,076.74	99.98%
1	III дугаар үе шат	MON-3947 COL	11,920,000,000.00	11,910,919,761.76	99.92%
2		MON-3946 OCR	3,863,000,000.00	3,831,504,400.00	99.18%
3		ЕХОБ 83873	13,555,500,000.00	13,555,198,721.73	100.00%
		Урсгал	1,370,500,000.00	1,370,435,931.77	100.00%
Нийт			30,709,000,000.00	30,668,058,815.26	99.87%
НИЙТ ДҮН			87,341,600,000.00	87,166,100,463.16	99.80%

Хүснэгт 2. 2024 оны Улсын төсвийн гүйцэтгэл

7. Төсөл, арга хэмжээний нийт ашиглалт:

(сая. ам доллараар)

д/д	Төслийн нэр	дүн	Ашиглалт /өссөн дүнгээр/	%
1	MON-3098 OCR	27.5	26.64	96.87%
2	MON-3099 COL	22.5	20.03	89.02%
3	MON-0380 Grant	3.7	3.69	99.73%
4	ЕХОБ 83097	22.01	22.01	100.00%
5	НЗДТГ	33.15	45.41	136.98%
Нийт		108.86	117.78	108.19%
1	MON-3525 OCR	37.11	25.83	69.60%
2	MON-3526 COL	29.24	28.17	96.34%
3	ЕХОБ 83873	19.64	15.22	77.49%
4	НЗДТГ	40.67	15.01	36.91%
Нийт		126.66	84.23	66.50%
1	MON-3947 COL	18.6	10.16	54.62%
2	MON-3946 OCR	25.05	6.71	26.79%
3	ЕХОБ 83873	18.65	8.72	46.76%
4	НЗДТГ	15.21	0.57	3.75%
Нийт		77.51	26.16	33.75%
НИЙТ ДҮН		313.03	228.17	72.89%

Хүснэгт 3 Төсөл, арга хэмжээний нийт ашиглалт

8. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хувь хэмжээ:


Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц нь 2024 оны 12 сарын 30-ны байдлаар 63.65% байна. Дараах хүснэгтээс үе шат бүрээр хэрэгжилтийг харна уу

Үйл ажиллагаа	Бодит явц
ТУН байгуулах	100.00%
1 дүгээр үе шатны үйл ажиллагаа	100.00%
2 дугаар үе шатны үйл ажиллагаа	60.85%
3 дугаар үе шатны үйл ажиллагаа	38.91%
Төслийн хаалт	0.00%
Хөтөлбөр	66.78%

Хүснэгт 4 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хувь хэмжээ

Хөтөлбөрийн үйл ажиллагаанууд нь харилцан хамаарал бүхий дараах үйл ажиллагаануудаас хамаарна. Үүнд:

1. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт: Төслийн баримт бичигт зааснаар төслийн хүрээнд хийгдэх газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааг 2009 оны 6 сард батлагдсан Азийн Хөгжлийн Банкны хамгааллын бодлогыг дагаж мөрдөх үүргийг МУ-ын тал гэрээгээр хүлээсэн байна. Иймд, төслийн хүрээнд хийгдэх барилга угсралтын ажлуудын газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулан, АХБ-аар батлуулснаар тухайн батлагдсан төлөвлөгөөний дагуу газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.
2. Инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулж, батлуулах: Төсөл арга хэмжээний нөлөөлөлд өртсөн нэгж талбаруудын газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг зохион байгуулж, төлөвлөсөн инженерийн болоод нийгмийн барилга байгууламжийн газрын гэрээ, гэрчилгээ гарснаар барилгын тухай хууль болон холбогдох дүрэм журмын дагуу тухайн баригдах барилга байгууламжийн ажлын даалгавар, техникийн нөхцөлүүдийг холбогдох мэргэжлийн байгууллагуудаас авч, зураг төсөл, төсвийг эцэслэн боловсруулж, магадлалаар батлуулдаг. Зураг төслийн ажил дууссанаар төслийн худалдан авах ажиллагааг эхлүүлэх боломж бүрддэг.
3. Төслийн худалдан авах ажиллагаа: Төслийн баримт бичигт зааснаар төслийн хүрээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг АХБ-ны худалдан авах ажиллагааны журмын дагуу АХБ-аас баталсан төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу АХБ-ны зохих хяналттайгаар зохион байгуулна.
4. Төслийн үйл ажиллагаа: Төслийн хүрээнд хүрээнд төлөвлөсөн аливаа барилга угсралтын ажлууд нь нарийвчилсан зураг төсөл боловсруулах, төслийн худалдан авах ажиллагаа (ХАА), газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлт (ГЧНШ) бүрэн дууссанаар хэрэгжиж эхлэх бөгөөд барилгын ажлыг зохиогчийн хяналт, захиалагчийн техникийн хяналттайгаар гүйцэтгүүлж, ашиглагч байгууллага бөгөөд төслийн үр шимийг хүртэгчид хүлээлгэн өгнө.




Зураг 2 Төслийн үйл ажиллагаа

Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрт заасны дагуу АХБ-ны худалдан авах ажиллагааны журам, Хамгааллын бодлогын баримт бичгийг баримтлан ажилдаг.

9. Тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн томоохон ажлууд:

9.1. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ





Зураг 4 Дэд төдийн байриил

Төслийн удирдах хороо (ТУХ) нь Төсөл, арга хэмжээний зорилгыг тогтоосон хугацаанд, бүрэн хэрэгжүүлэх зорилгоор хэрэгжилтийг нэгдсэн бодлого, удирдлагаар хангаж, салбарын бодлоготой уялдуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг (НИТХ) тэргүүлэгчдийн 2014 оны 107 тоот тогтоолоор Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг анх баталсан бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/322 тоот захирамжаар Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, Төслийн удирдах хорооны даргаар Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч ажиллаж байна.

Монгол улсын сангийн сайдын 2023 оны 69 тоот тушаалаар “Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр (УБГХХХОДХ)”-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц орон тоог шинэчлэн нийт 26 ажилтантай баталсан.

Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) нь Төслийн зохицуулагч, хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн, худалдан авах ажиллагааны мэргэжилтэн, санхүүгийн ажилтан 2, гэрээ, эрх зүйн мэргэжилтэн, нүүлгэн шилжүүлэлтийн мэргэжилтэн 2, байгаль орчны мэргэжилтэн, нийгмийн хамгаалал, жендерийн мэргэжилтэн, олон нийтийн оролцоог хангах мэргэжилтэн, барилгын инженер 2, авто замын инженер 2, усан хангамж, ариутгах татуургын шугамын инженер 2, цахилгааны инженер, дулааны инженер 2, хот төлөвлөлтийн мэргэжилтэн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн, орчуулагч, туслах ажилтан, жолооч 2, Мэдээллийн технологийн ажилтан гэсэн нийт 26 хүний орон тоотой төслийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд төслийн нэгж 22 ажилтантайгаар ажиллаж байгаа бөгөөд худалдан авах ажиллагааны мэргэжилтэн, авто замын инженер, дулааны инженер, хот төлөвлөлтийн мэргэжилтэн нарын ажлын байрыг зарлан сонгон шалгаруулалт хийгдэж байна.

Хөтөлбөрийг 2013 оны 12 сард УИХ-аар соёрхон батлуулан хэрэгжүүлэн эхэлсэн бөгөөд нийт төлөвлөсөн хэрэгжүүлэх хугацааны 84.9% нь буюу 134 сар өнгөрөөд байгаа дараах зайлшгүй нөхцөл байдлуудын улмаас төслийн хэрэгжилтийн явц удаашраад байна. Үүнд:

- Хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн хариуцах газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн тухайн он, оны төсөв хөрөнгө дутмаг, үүнтэй холбоотойгоор АХБ-ны зээлийн хөрөнгөөр ГЧНШ хийхээр шийдвэрлэн гүйцэтгсэн
- Дэлхий нийтэд тархаад байгаа Ковид-19 цар тахлаас сэргийлэх Засгийн газраас хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн хүрээнд нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн иргэдтэй уулзалт зохион байгуулах, зөвшилцөх ажлыг 2 жилийн хугацаанд зохион байгуулах боломжгүй байсан.

- Мөн энэхүү цар тахлын тархалт улам ихэссэнээр олон нийтийн хөл хорио тогтоон барилгын ажлыг зогсоосон мөн барилгын материал татан авалтад хугацаа их зарцуулсан. (2020 оны 11 сард Монгол Улсад Ковид19-ын анхны тохиолдол бүртгэгдсэнээс хойш нийт 7 удаагийн нийт 78 хоногийн хатуу хөл хорио тогтоосон бөгөөд 2020 оны 1 сараас эхлэн БНХАУ-ын хил хаагдсанаас материал тээвэр, татан авалт хүндрэл ихтэй, удаашралтай болсон.) Мөн үүнтэй холбоотойгоор 2020 онд байгуулсан гэрээний үнийн өсөлтийн асуулдуудыг шинэчлэн батлагдаж байгаа журамуудын дагуу шийдвэрлэхэд хугацаа ихээр зарцуулж ажлуул зогсонги байдалтай байна.
- Дээрх нөхцөл байдалтай холбоотойгоор дотоодын зах зээл дээр барилгын материалын үнэ огцом өсөж, 2021 онд гэрээ байгуулагдсан зарим төсөл арга хэмжээний үнийн өсөлтийг холбогдох хууль, тогтоомж, Сангийн яам, АХБ хооронд байгуулсан санамж бичгийн дагуу шийдвэрлэх удаашралтай шийдвэрлэсэн нь төслийн хэрэгжилтэд тодорхой хэмжээнд нөлөөлсөн.
- Дамжуулан зээлдүүлэх зээлийн хэлэлцээрт заасан Нийслэлийн хариуцах барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн санхүүжилт гэрээнд заасан хугацаанд олгогдоогүй, хугацаа хоцорсноор барилгын дараагийн үе шатны ажлуудыг гүйцэтгэл удааширахад нөлөөлсөн. Жишээ нь: 2016 оноос хойш жил бүр ТХН-ээс хүргүүлсэн төсвийн саналын 32%-ыг дунджаар баталсан байна, НЗДТГ-ын төсвөөс санхүүжүүлэх 1 төлбарт зарцуулсан дундаж өдөр нь хөтөлбөрийн 1 үе шатны хувьд 302 өдөр, 2 үе шатны хувьд 205 өдөр байна.

АХБ-наас төслийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсэг 2023 оны 03-р сард төсөл дээр ажилласан бөгөөд төслийн хүрээнд тулгамдаж байгаа асуудлуудыг холбогдох талуудтай хэлэлцэн цар тахал болон бусад тулгамдаж буй нөхцөл байдлаас шалтгаалан төслийн хөрөнгө оруулалтуудыг хэрхэн дахин хуваарилах, хөтөлбөрийн хугацааг сунгах шийдвэрүүдийг гарган, хөтөлбөрийн хугацаа сунгах хүсэлтийг АХБ-ны захирлуудыг зөвлөлд танилцуулж, холбогдох талуудын шийдвэрээр төслийн хэрэгжих хугацааг 2026 оны 12 сарын 11 хүртэл сунгаад байна.

Эхэлсэн хугацаа	Дуусах хугацаа	Сунгасан хугацаа
2014.09.30	2023.12.11	2026.12.11

Хүснэгт 5 Төсөл хэрэгжих хугацаа

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад 2024 оны 11 сарын 14-19-ны хооронд АХБ-ны ажлын хэсэг ажилласан бөгөөд гэрээнүүдийн үнийн өсөлтөөс шалтгаалан зарим ажлуудын санхүүжилтийн эх үүсвэрийг солих талаар хэлэлцэн худалдан авалтын төлөвлөгөөг өөрчлөх ажлуудыг гүйцэтгэж байна.

Хөтөлбөр хэрэгжсэнээр дараах 4 үр дүнд хүрэхээр боловсруулагдсан:

- тэргүүлэх ач холбогдол бүхий дэд төвүүдэд авто зам болон хотын дэд бүтцийн үйлчилгээ өргөжиж, тэдгээрийн хоорондын холболт сайжирна;
- зорилтот хэсгүүд дэх эдийн засгийн болон төрийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ;
- дэд бүтцийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааны үр дүн сайжирна;
- хот байгуулалт, хөтөлбөрийн менежмент, үйлчилгээг хүргэх чиглэлээр институци болон чадавх бэхэжнэ.

Хөтөлбөрийг гурван шаттайгаар хэрэгжүүлж байна.

ХӨТӨЛБӨРИЙН 1 ДҮГЭЭР ҮЕ ШАТНЫ хүрээнд Сонгинохайрхан дүүргийн (СХД) 7,8,9,10,28,40 дүгээр хороод буюу Баянхошуу дэд төвд 15.3км ариутгах татуургын, 10.4км ус хангамжийн, 17.8 км дулааны, 6.3км цахилгааны, 2.9км холбооны шугам сүлжээ, 17.1 км

Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

шилэн кабель, 4.8км үерийн хамгаалалтын суваг, 6.5 км авто зам, 1000м³ усан сан, 2 цэвэр усны насос станц, 14 УДДТ, 7 КТПН дэд өртөө, 1 хуваарилах байгууламж, 2 хаалттай дэд өртөө, 4.65 га талбайн тохижилт, 240 хүүхдийн цэцэрлэг, 1 бизнес инкубатор төв, 20 айлын орлогод нийцсэн орон сууц, 1 мэдээлэл холбооны төв /Хавсралт 1/,

Чингэлтэй дүүргийн (ЧД) 14,18, Сүхбаатар дүүргийн (СБД) 13,14 дүгээр хороод буюу Сэлбэ дэд төвд 11.9км ариутгах татуургын, 8.9км ус хангамжийн, 9.2км дулааны, 2.4км цахилгааны, 2.7 холбооны шугам сүлжээ, 19.5 км шилэн кабель, 2.1км үерийн хамгаалалтын суваг, 6.6км автозам, 3 төмөр бетон гүүр, 1000м³ усан сан, 1 цэвэр усны насос станц, 14 УДДТ, 6 КТПН дэд өртөө, 4 хаалттай дэд өртөө, 28МВт-ын дулааны станц 3.01 га талбайн тохижилт, 240 хүүхдийн цэцэрлэг, 1 бизнес инкубатор төв, 1 мэдээлэл холбооны төв зэргийг тус бүр барьж ашиглалтад оруулсан /Хавсралт 2/

Ус Сувгийн Удирдах Газар (УСУГ) ОНӨААТҮГ-т үзүүлэх олон талт дэмжлэгийн хүрээнд түүний үйл ажиллагааны болон ус хангамж, бохир ус татан зайлуулах үйлчилгээний үр ашгийг дээшлүүлж /Хавсралт 3/;

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төслийн нэгжийн чадавхыг бэхжүүлэх дэмжлэгийн хүрээнд: (a) нарийвчилсан зураг төсөл боловсруулах, барилгын ажилд хяналт тавих, (b) олон нийт оршин суугчдын оролцоог дэмжих, тэдний ойлголтыг төлөвшүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх; (c) дэд төвүүдийг дахин төлөвлөлтөөр хөгжүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох; (d) Хөтөлбөрийг удирдах алба (ХУА)-ны чадавхыг бэхжүүлэх; (e) дэд бүтцийн үйлчилгээний байгууллагуудад хийгдэх шинэчлэл зэрэг чиглэлээр хэрэгжүүлж дараах үр дүнг гаргаад байна Үүнд:

- Дунд оврын 29 зуух буулгаж, 2021 оны өвлөөс эхлэн жил бүр 18,500тн түүхий нүүрсний хэрэглээ буурсан.
- 7,570 иргэн, 62 аж ахуй нэгж төвлөрсөн дулааны эх үүсвэрт холбогдсон.
- Ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсоноор 1236 модон жорлон утсан.
- 25 мянга гаруй иргэд цэвэр усны найдвартай эх үүсвэрээр хангагдсан.
- Агаарын багана бүхийн шилэн кабелийн сүлжээ нь 3,000 өрхийг хашааны гаднаас өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд холбогдох боломжийг хангаж, эдгээр өрхийн дата хэрэглээний 36 сая төгрөгийн хэмнэлтийг 1 жилд үүсгэж байна
- Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв нь Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн 160 мянган иргэдийг хотын төв оролгүйгээр төрийн үйлчилгээг авах боломжийг бүрдүүлсэн.
- Тус дэд төвүүдийн цэцэрлэгт хамрагдаж чаддаггүй байсан 596 хүүхэд жил бүр цэцэрлэгт хамрагдаж, нийт 79 багш ажилчид ажлын байртай боллоо.
- МСҮТ, бизнес инкубатор төвийн барилгын угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв нийт 198 төрлийн төрийн үйлчилгээ, Нийслэлийн нийтлэг үйлчилгээний төвийн салбар, Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацийн газар, инкубатор өрөөнд бойжигчид, Төсөл хэрэгжүүлэх нэгж, Иргэдийн мэдээллийн төв, Азийн Сангийн Бизнес Эрхлэгч эмэгтэйчүүдийн төв, бизнес эрхлэгч эмэгтэйчүүд, Дэлхийн Зөн, Төгсөлтийн аргачлал-600, зорилтот өрхийн бүлэг, Дэд төвийн хороодын бизнес эрхлэгч иргэд(үсчин, үндэсний гутал хийдэг гэр бүл) гэх мэт байгууллага, иргэд үйл ажиллагаагаа явуулж, нийт 73 хүн байнгын ажлын байртай боллоо.
- Нийт 246 айлын орлогод нийцсэн орон сууц ашиглалтад оруулж түрээслээд өмчлөх нөхцөлөөр айл өрхүүдийг оруулаад байна.



Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

- Нийт 1236 айл өрх газраа чөлөөлснөөс ¹78% нь орон сууцанд амьдарч байна

Хөтөлбөрийн II үе шат болон III үе шатны хүрээнд (i) I үе шатны хүрээнд хамрагдсан дэд төвүүдэд хийгдсэн хөрөнгө оруулалтын хамрах хүрээг өргөжүүлж, Дамбадаржаа, Толгойт дэд төвүүдийг хамруулж дээрх чиглэлээр үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

¹ Төслийн нэгжээс газраа чөлөөлсөн иргэн бүртэй холбогдон баталгаажуулсан.

9.1.1.ХӨТӨЛБӨРИЙН ХОЁР ДУГААР ҮЕ ШАТ

9.1.1.1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хөтөлбөрийн II үе шатны хүрээнд (i) хотын хойд хэсэгт байрладаг Дамбадаржаа, Дэнжийн дэд төвүүдэд хотын дэд бүтцийг шинэчлэх өргөтгөх, Баянхошуу, Сэлбэ дэд төвд нэмэлт хөрөнгө оруулалт хийх, (ii) нийгэм эдийн засгийн барилга байгууламж барих, (iii) чадавх бэхжүүлэх үйл ажиллагаануудыг хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн I үе шатны дэд төвүүдээс гадна хөтөлбөрийн II үе шатнаас нийт 29,605 хүн (7,220 өрх) үр шим хүртэнэ. Үүнээс Дамбадаржаад буюу Сүхбаатар дүүргийн 16, 17 болон 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 70.7 га талбайд 7,105 хүн 1732 өрх, Дэнжийн мянга буюу Чингэлтэй дүүргийн 10, 11, 12 болон 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 131.5 га талбайд 22,500 хүн, 5488 өрх амьдарч байна.

Үе шат 2-ын зээлийн хэлэлцээрийг 2017 оны 12 сарын 6-нд батлуулсан.

(сая ам.доллар)

Эх үүсвэр	Санхүүжилт		Эзлэх хувь
	Анхны төлөвлөсөн	Шинэчлэгдсэн	
АХБ-ны санхүүжилт			
МОН-3025 (COL)	29.24	29.24	23.09
МОН-3026 (OCR)	37.11	37.11	29.30
Дэд дүн	66.35	66.35	52.38
НЗДТГ-ын төсөв	35.15	40.67	32.11
ЕХОБ-ны санхүүжилт FI'83097	19.64	19.64	15.51
Нийт	121.14	126.66	100.00

Хүснэгт 6 Хөтөлбөрийн 2 үе шатны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

Хөтөлбөрийн II үе шатыг дараах бүрэлдэхүүн хэсгүүдээр хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх
2. Нийгэм, эдийн засгийн барилга байгууламжууд
3. Төсөл хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх

Хөтөлбөрийн II үе шатны хүрээнд Дамбадаржаа, Дэнжийн мянга төвүүдийн бүтээн байгуулалтыг хийх бөгөөд Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд зайлшгүй шаардлагатай нэмэлт бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэж байна. II үе шатны хэрэгжилтийн явц 60.85% байна.


Үйл ажиллагаа	Бодит явц
Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлт	96.4%
Төлөвлөлт	92.2%
Хэрэгжүүлэлт	98.3%
Зураг төсөл боловсруулалт	90.8%
Худалдан авах ажиллагаа	76.9%
Барилгын ажил	73.9%
Зөвлөх үйлчилгээ	95.4%
Бараа	82.2%
Барилга угсралт	39.7%
Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх	37.9%
Нийгэм, эдийн засгийн барилга байгууламжууд	46.1%
Зөвлөх үйлчилгээ	64.2%
Нийт	60.9%

Хүснэгт 7 Хэрэгжилтийн явц



Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

Хөтөлбөрийн II үе шатны хүрээнд Дэд төвүүдийн хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөсөн бөгөөд барилгын ажлууд эхэлсэн байгаа бөгөөд барилгын ажлуудын хэрэгжилтийн тоймыг дараах графикаас харна уу



Зураг 5 Хөтөлбөрийн 2 үе шатны барилгын ажлуудын хэрэгжилтийн тойм

9.1.1.2. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 4 сард шинэчлэгдэн АХБ-аар батлуулсан бөгөөд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 14 дахь хувилбарт 34 барилгын ажил, 9 бараа, 6 зөвлөх үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулахаар төлөвлөснөөс 23 барилгын ажил, 4 бараа, 5 зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулаад байна.

Хөтөлбөрийн II үе шатны ХАА-ны үйл ажиллагааг дор хүснэгтэд тоймлов.

№	Ажлын нэр	Худалдан авалтын явц
ЗАРЛАСАН ХАА		

№	Ажлын нэр	Худалдан авалтын явц
1	СЕР-1 багц 1: Дамбадаржаа дэд төвийн 83 дугаар шугамын ус түгээх байрны тохижилтийн ажил	- Төслийн дуусах хугацаа, тохижилтийн ажлын тендер оролцогчгүй байгаа зэргийг харгалзан төслийн санхүүжүүлэгч АХБ-аас тус ажлыг төсөл дээр одоо гэрээт ажил гүйцэтгэж буй барилга угсралтын компаниудтай зөвшилцөн гэрээний нэмэлт өөрчлөлтөөр гүйцэтгүүлэхийг зөвшөөрсний дагуу тухайн дэд төвд барилга угсралтын ажил гүйцэтгэж буй төслийн гүйцэтгэгч компаниас тус ажлыг гүйцэтгэх үнийн саналыг хүлээн авсан. Ирүүлсэн үнийн санал нь батлагдсан төсөвт өртгөөс 30 гаруй хувь өндөр байсан тул тус ажлыг харьцуулалтын аргаар зарлаж, тендерийн нээлтийг 2024 оны 12 сарын 23-ны өдөр зохион байгуулсан. Тендерийн үнэлгээ хийгдэж байна.
	СЕР-1 багц 2: Баянхошуу дэд төвд 3х3 сагсан бөмбөгийн талбай барих ажил	- Төслийн дуусах хугацаа, тохижилтийн ажлын тендер оролцогчгүй байгаа зэргийг харгалзан төслийн санхүүжүүлэгч АХБ-аас тус ажлыг төсөл дээр одоо гэрээт ажил гүйцэтгэж буй барилга угсралтын компаниудтай зөвшилцөн гэрээний нэмэлт өөрчлөлтөөр гүйцэтгүүлэхийг зөвшөөрсний дагуу тухайн дэд төвд барилга угсралтын ажил гүйцэтгэж буй төслийн гүйцэтгэгч компаниас тус ажлыг гүйцэтгэх үнийн саналыг хүлээн авч, АХБ-наас гэрээний нэмэлт өөрчлөлтийн зөвшөөрлийг 2024 оны 11 сарын 25-нд олгосон.
ЗАРЛАХААР ТӨЛӨВЛӨСӨН ХАА		
2	СЕР-2: Дамбадаржаа дэд төв дэх 58 дугаар Бага сургуулийн саадгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх ажил	- Төслийн дуусах хугацаа, тохижилтийн ажлын тендер оролцогчгүй байгаа зэргийг харгалзан төслийн санхүүжүүлэгч АХБ-аас тус ажлыг төсөл дээр одоо гэрээт ажил гүйцэтгэж буй барилга угсралтын компаниудтай зөвшилцөн гэрээний нэмэлт өөрчлөлтөөр гүйцэтгүүлэхийг зөвшөөрсний дагуу тухайн дэд төвд барилга угсралтын ажил гүйцэтгэж буй төслийн гүйцэтгэгч компаниас тус ажлыг гүйцэтгэх үнийн саналыг хүлээн авсан. Ирүүлсэн үнийн санал нь батлагдсан төсөвт өртгөөс 30 гаруй хувь өндөр байсан тул тус ажлыг ДӨТШ-ын аргаар зарлахаар ТББ-ийг боловсруулж байна.
3	SHFP: Шар хад дэд төвийн үерийн хамгаалалт, ус зайлуулах байгууламжийн ажил (дахин зар)	- Энэхүү тендер шалгаруулалтыг дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалтын аргаар 2 удаа, гэрээ шууд байгуулах аргаар 1 удаа тус тус 2023 онд зохион байгуулж, амжилтгүй болсон - 2024 оны 7 сард тендерийг ДӨТШ-ын аргаар дахин зарласан боловч Баянзүрх дүүргийн хөрөнгө оруулалтаар 10, 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан 1.8 км авто замын барилга угсралтын ажил үерийн далангийн трасстай давхцсан тул тус тендерийг цуцласан. - Зураг төслийг ахин шинэчилж байна.
4	DAFKA: Дамбадаржаа дэд төвийн 150 хүүхдийн цэцэрлэгт тавилга, гал тогооны тоног төхөөрөмж болон бусад эд зүйлс худалдан авах	- Барилгын ажил удаашралтай байгааг харгалзан эхний тендер шалгаруулалтыг цуцалсан. Барилгыг ашиглалтад орох хугацаатай уялдуулан тендерийг дахин зарлана
5	BKHCDCFKA: Баянхошуу дэд төвийн Олон нийтийн хөгжлийн	- Барилгыг ашиглалтад орох хугацаатай уялдуулан тендерийг дахин зарлана.

№	Ажлын нэр	Худалдан авалтын явц
	төвд тавилга, тоног төхөөрөмж худалдан авах	
6	ВКНСЕ: Баянхошуу дэд төвийн спорт комплекст тоног төхөөрөмж худалдан авах (дахин зар)	- Эхний тендер шалгаруулалтад нэг ч тендер ирээгүй болно - 2дох удаагийн тендер шалгаруулалтаар Багц 1 болон Багц 3-т шаардлага хангасан нэг ч тендер ирээгүй бөгөөд Багц 2-ын хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчтой гэрээг 2024 оны 9 сарын 25-нд байгуулсан.
7	ВКНСФ: Баянхошуу дэд төвийн спорт комплекст тавилга, тоног төхөөрөмж худалдан авах (дахин зар)	- Эхний тендер шалгаруулалтад нэг ч тендер ирээгүй болно - 2дох удаагийн тендер шалгаруулалтаар Багц 1 болон Багц 2-т шаардлага хангасан нэг ч тендер ирээгүй бөгөөд Багц 3-ын хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчтой гэрээг 2024 оны 8 сарын 14-нд байгуулсан.
8	ДНРТС: Дамбадаржаа дулааны станцын зуух, тоноглол угсралтанд үйлдвэрлэлийн болон техникийн туршилт хийж, байнгын ашиглалтад оруулах магадлал хийн баталгаажуулж, ашиглах зөвшөөрөл олгох зөвлөх үйлчилгээ	- Ажлын даалгаврыг боловсруулж байна.
ХАА-НЫ ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС ХАСАХААР ТӨЛӨВЛӨСӨН		
9	ВКНС - Баянхошуу дэд төвд баригдах "Плаза"-н барилга угсралтын ажил (дахин зар)	- Энэхүү тендер шалгаруулалтыг дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалтын аргаар 2023 онд 2 удаа, гэрээ шууд байгуулах аргаар 2 удаа тус тус зохион байгуулж, амжилтгүй болсон - Төслийн дуусах хугацаа, санхүүжилтийн төлөвлөгөө зэргийг харгалзан тус ажлыг "Улаанбаатар хотын Орлогод нийцсэн, ногоон орон сууц ба хотын шинэчлэл төсөл"-ийн хүрээнд гүйцэтгэхээр зөвшилцөн, зураг төслийг хүлээлгэн өгсөн бөгөөд төслийн ХАА-ны төлөвлөгөөг 2025 онд шинэчлэх үеэр төлөвлөгөөнөөс хасахаар АХБ-тай зөвшилцсөн.

Хүснэгт 8 Худалдан авалтын үйл ажиллагаа

Худалдан авалтын төлөвлөгөөнд нийт 7 багц ажлыг НЗДТГ-ын санхүүжилтээр хийхээр төлөвлөсөн боловч тухайн ажлуудад 2024 онд төсөв хувиарлаагүй тул энэхүү ажлууд зогсонги байдалтай байна. Үүнд дараах ажлууд багтсан байна.

Дамбадаржаа дэд төвд

- Спорт цогцолбор

Дэнжийн мянга дэд төвд

- Дулааны станц
- Цахилгааны шугам 10.2 км
- Холбооны шугам 3.9 км
- Мэдээлэл холбооны төв
- Үерийн далан суваг 3.5 км
- Бохир усны шугам 5.7 км
- Цэвэр усны шугам 8.2 км
- Дулааны шугам 8.2 км
- Авто зам 0.7 км
- 240 Хүүхдийн цэцэрлэг

Худалдан авалтын үйл ажиллагааны явц 76.89%-тай байна.

Энэхүү үе шатны хүрээнд байгуулсан гэрээний хэрэгжилтийн мэдээллийг Хавсралт 4-т үзүүлэв.

9.1.1.3. БАРИЛГЫН АЖЛЫН ЯВЦ

Хөтөлбөрийн II үе шатны хүрээнд нийт 23 барилгын ажлын гэрээ байгуулснаас барилгын ажлын хэрэгжилтийн явц 39.65%-тай байгаа бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр дараах байдалтай байна.

БҮРЭЛДЭХҮҮН 1. АВТО ЗАМ БОЛОН ХОТЫН ҮНДСЭН ҮЙЛЧИЛГЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 16 барилгын ажлын гэрээ байгуулснаас 10 барилгын ажил бүрэн дуусаж ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх үйл ажиллагаа үргэлжилж байна. Гэрээ байгуулан гүйцэтгэгдэж байгаа ажлын тоо хэмжээг дараах хүснэгтээр харуулав.

№	Багцын дугаар	Ажлын нэр	Ажлын тоо хэмжээ	Ажлын явц	
				2023. 12.30	2024. 12.30
АХБ-ны санхүүжилт					
1	GWD 14	Сэлбийн хөрсний ус зайлуулах 2,2 км шугамын ажил	Ф800мм ус шүүрүүлэх бетон хоолой 1799м, Ф1000 бетон хоолой 2891м, Ф1500мм-н угсармал төмөр бетон худаг 35ширхэг	100%	100%
2	GWD 11	Сэлбийн хөрсний ус зайлуулах 1,3 км шугамын ажил	Ф800мм ус шүүрүүлэх бетон хоолой 1305м	100%	100%
3	BHF06B	Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаан хангамжид холбох, дулааны даралт өргөх, насос станц, ус дулаан дамжуулах төв, дулааны шинэ шугамын зураг төсөл, ханган нийлүүлэлт, угсралтын ажил	Өргөлтийн насос станц Ус дулаан дамжуулах төв Дулааны шугам, 3.05км 2*400кВА Дизель генератор 2*160кВА хаалттай дэд өртөө 2*250кВА хаалттай дэд өртөө	100%	100%
4	DARI-1	Дамбадаржаа дэд төв орчмын дэд бүтцийн барилга угсралтын ажил	Ариутгах татуургын шугам – 3.3км Ус хангамжийн шугам – 2.8 км	28.82%	61.82%
5	DARI-2	Дамбадаржаа дэд төв орчмын дэд бүтцийн барилга угсралтын ажил	УДДТ – 4ш Дулааны шугам – 2.6 км Автозам – 2.8 км Хөрсний ус зайлуулах шугам – 1.6 км	22.79%	57.28%
6	DAEC	Дамбадаржаа дэд төвд баригдах цахилгаан болон холбооны шугам сүлжээний барилга угсралтын ажил	6.6 км урт 10кВ цахилгааны кабель; 10кВ хуваарилах байгууламж-1 иж бүрдэл; 10/0.4кВ 2х400кВА-н дэд өртөө-1 иж бүрдэл; 5.9 км урт холбооны худаг, сувагчлал; 4.8 км урт шилэн кабель;	5.90%	43.69%

№	Багцын дугаар	Ажлын нэр	Ажлын тоо хэмжээ	Ажлын явц	
				2023. 12.30	2024. 12.30
			Мэдээлэл холбооны нэгдсэн төвийн барилга-1 иж бүрдэл		
7	ДАНР	Дамбадаржаа дэд төвд баригдах дулааны станц	НТБҮШ Зуух - 3х21МВт, Нүүрсний агуулах - 2800тн, Нүүрс бутлуур - 2х60тн/ц, Утаа сорогч - 3х75000м3/ц, Үнсний агуулах - 20х20м, Утааны яндан - 86м, Үнсний бункер - 60м3, Шохойн чулууны бункер - 60м3, Агуулахын барилга - 18х10м, Усны савны барилга - 17х17м, Дизель түлш нөөцлөх сав - 5тн, Дулааны станцын үндсэн барилга - 1572м2	0%	6.83%
ЕХОБ-ны санхүүжилт					
8	HSSC-A1	Шинэ суурьшлын бүсэд хийгдэх сайжруулсан нүхэн жорлон суурилуулах	66ш сайжруулсан нүхэн жорлон суурилуулах	100%	100%
9	HSSC-A2	Шинэ суурьшлын бүсэд хийгдэх сайжруулсан нүхэн жорлон суурилуулах	23ш сайжруулсан нүхэн жорлон суурилуулах	100%	100%
10	HSSC-B	2-р хэлхээний дулаан хангамж, хэрэгцээний халуун ус, цэвэр усны шугам сүлжээний угсралтын ажил	СБД-н 14-р хороо, Өрхийн эмнэлгийн дулаан хангамжийн системд холбох - 500м 35-р сургуулийг дулаан хангамжийн системд холбох - 1315м 51-р цэцэрлэгийг дулаан хангамжийн системд холбох- 615м Түр суурьшуулах 50 айлын орон сууцыг дулаан хангамжийн системд холбох- 200м 280-р цэцэрлэгийг дулаан хангамжийн системд холбох- 900м Сэлбийн бизнес инкубатор, МСҮТ-ийг дулаан хангамжийн системд холбох-1085м Дулааны узель угсрах-8ш	100%	100%
11	WSC16B	Шархад дэд төвийн Цайз эко хотхон хорооллыг төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын шугам, халуун, дулааны шугам, болон цахилгаан	Ус дулаан дамжуулах төв Дулааны шугам, 0.594км Цэвэр усны шугам, 0.594км Бохир усны шугам, 2,3 км Хаалттай дэд өртөө Гадна цахилгаан	100%	100%

№	Багцын дугаар	Ажлын нэр	Ажлын тоо хэмжээ	Ажлын явц	
				2023. 12.30	2024. 12.30
		хангамжийн шугамд холбох зураг төсөл, ханган нийлүүлэлт, угсралтын ажил			
12	USF	Морингийн даваа орчмын шинэ суурьшлын бүсийг инженерийн хангамжийн шугам сүлжээнд холбох	Гадна цэвэр усны шугам, 5.3км Усны сангийн барилга, 1000м ³ Усан сангийн харуулын байрны барилга Гадна бохир усны шугам, 2.7км Насос станцын барилга, харуулын байр, 2ш Гадна цахилгаан хангамж, 12.8км Хуваарилах байгууламж Гадна холбооны ажил, 4км	99%	100%
13	DAFPE	Дамбадаржаа дэд төв орчмын үерийн хамгаалалтын далан угсралтын ажил	1.7 км үерийн далан	99%	100%
14	HSSC-C	Баянхошуу дэд төвийн нийгмийн байгууламжийн усан хангамж, ариутгах татуурга, ахуйн хэрэглээний халуун ус, дулааны шугам сүлжээ, цахилгааны холболтын угсралтын ажил	Ариутгах татуургын шугам – 366м Ус хангамжийн шугам – 2.4 км УДДТ – 2ш Дулааны шугам – 5.8 км Дулааны насос станц – 1ш Хаалттай дэд өртөө - 2ш	76.30%	91.30%
15	HSSC-D	Сэлбэ дэд төвийн 2-р хэлхээний инженерийн шугам сүлжээний угсралтын ажил	Ус Дулаан Дамжуулах төвийн барилга угсралт, тоноглол угсралтын ажил /СБД, 13 дугаар хороо/ Шинээр баригдаж буй 960 хүүхдийн сургууль, Шинээр баригдах Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг, 248, 150-р цэцэрлэг гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил /СБД, 13 дугаар хороо/ Ус дулаан дамжуулах төв 12-оос 7 буудал хүртэлх 2 дугаар хэлхээний дулаан, хэрэгцээний халуун ус, цэвэр усны шугам сүлжээний холболт /СБД, 14 дүгээр хороо/	99%	100%
16	SHTSC-A	Сонгинохайрхан дүүргийн 2 дугаар хороо, Цэргийн хотхон орон сууцны хороолол орчмын "Б" хэсэгчилсэн талбай дах гадна дулаан хангамжийн	Ф530х8мм-ийн голчтой 1.3 км дулааны шугамын угсралтын ажил 28метр авто замын доогуурх нэвтрэх сувгийн ажил 24метр төмөр замын доогуурх нэвтрэх сувгийн ажил	0%	43.60%



Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

№	Багцын дугаар	Ажлын нэр	Ажлын тоо хэмжээ	Ажлын явц	
				2023. 12.30	2024. 12.30
		инженерийн шугам сүлжээний ажил			

Хүснэгт 9 Гэрээ байгуулан гүйцэтгэгдэж байгаа ажлууд

БҮРЭЛДЭХҮҮН 2. НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 5 барилгын ажил үргэлжлэн хийгдэж байна.

№	Багцын дугаар	Ажлын нэр	Ажлын тоо хэмжээ	Ажлын явц	
				2023. 12.30	2024. 12.30
		АХБ-ны санхүүжилт			
1	SHS	Нүүлгэн шилжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх 126 айлын түрээсийн орон сууц	126 айлын орон сууцны барилга, гадна тохижилт, гадна шугам сүлжээ	99%	100%
2	ASKG-BKH	240-н хүүхдийн цэцэрлэгийн барилга /Баянхошуу дэд төв/	Баянхошуу дэд төвд баригдах 10 бүлгийн нийт 240 хүүхдийн 2 давхар төмөрбетон каркастай цэцэрлэгийн барилга угсралтын ажил. /2316 м.кв цэцэрлэгийн барилга, 1168 м.кв тоглоомын талбай/	17.25%	17.25%
3	DDPK-BKH	2га талбайд Цэцэрлэгт хүрээлэн /Баянхошуу дэд төв /	Нийт 2 га газарт 8336 м.кв бүхий ногоон байгууламж, нийтийн бие засах газар, эргүүлийн пост, авто машины ил зогсоол, хөлбөмбөг, сагсан бөмбөгийн гадна талбай, хүүхдийн тоглоомын талбай болон гимнастикийн хэсэг зэргээс бүрдэнэ	81.35%	81.35%
4	DDCD-BKH	Олон Нийтийн Хөгжлийн төв /Баянхошуу дэд төв/	Барилга нь 1121 м.кв талбайтай, 50-80 хүний багтаамжтай олон нийтийн арга хэмжээ явуулах танхим, 36 хүний багтаамжтай сургалтын танхим, 10 хүний багтаамжтай ахмадын өдөр өнжүүлэх, хүүхдийн сургалтын танхим, 50-80 хүний багтаамжтай заал, оффисын өрөө	28.00%	28.00%
5	BDSC-BKH	Спорт цогцолбор /Баянхошуу дэд төв/	Барилга нь 5761 м.кв талбайтай, 18424 м.кв гадна задгай зам талбайтай, 610 хүний суудал бүхий усан бассейн болон олон зориулалтын спорт заал болон чөлөөт, самбо, бокс гэх мэт бэлтгэл сургуулилтын өрөөнүүдтэй байна.	55.25%	74.50%

№	Багцын дугаар	Ажлын нэр	Ажлын тоо хэмжээ	Ажлын явц	
				2023. 12.30	2024. 12.30
6	ASKG-DA	Дамбадаржаа дэд төвд баригдах цэцэрлэгийн барилга угсралтын ажил	Төлөвлөж буй эдэлбэр газрын хэмжээ нь 3147 м ² , барилгажилтын талбай нь 2459.5м ² , нийт 150 ортой, 2 давхар төмөрбетон карказан барилга	0%	70.08%

Хүснэгт 10 Барилгын ажлын явц

2 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд гүйцэтгэгдэж байгаа барилгын ажлын зургийг Хавсралт 5-д үзүүлэв.

ASKG-BKH, DDCD-BKH, DDPK-BKH гэрээт ажлуудын хувьд:

- Ковид-19 цар тахлаас нөлөөгөөр барилгын материалын үнийн өсөлтөөс шалтгаалж, барилга угсралтын ажил 2021,2022 оноос хойш барилга угсралтын ажил зогссон.
- 2022 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн Барилга хот байгуулалтын сайдын 75 дугаар тушаалаар батлагдсан “улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих барилга байгууламжийн төсөвт өртгийн /барилгын материалын үнэ/ өөрчлөлтийг тооцох түр журам”-н дагуу үнийн өсөлтийг тооцуулах санал хүргүүлсэн ч, гүйцэтгэгч байгууллагаас зөвхөн барилгын материалд үнэ тооцуулахад төсөв хүрэлцэхгүй гэдэг шалтгаанаар магадлал хийлгээгүй.
- Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 95 дугаар тушаалаар батлагдсан “Тарифт цалингийн жишиг шинэчлэн батлах тухай” тушаалын дагуу тарифт цалинг тооцуулах талаар Барилгын хөгжлийн төв рүү 2024 оны 7 болон 9 сард хүсэлт хүргүүлсэн. Одоогоор Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас тодорхой чиглэл ирээгүй гэдэг шалтгаанаар хүлээгдэж байна.

Тайлант хугацаанд

- DAFPE "Дамбадаржаа дэд төвд баригдах үерийн хамгаалалтын далан, сувгийн барилга угсралтын ажил гүйцэтгэх" гэрээнд улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулахтай холбоотойгоор гэрээний хугацааг 2024 оны 7 дугаар сарын 30 өдөр хүртэл сунгасан.
- WSNR 17A “Улаанбаатар хотын Зүүн хойд бүсийн усан сангаас Тасганы усан сан хүртэлх HDPE 900мм-ийн 4010 метр урт цэвэр ус дамжуулах гол шугамын болон Ф600мм-ийн 1684,23 метр урт “9Б” бохир ус зайлуулах зөөлөн ширмэн яндан хоолой шугамын барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээнд инженерийн зураг төсөл өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 2,549,844,235.33 төгрөгөөр гэрээний үнийн дүнг нэмэгдүүлж гэрээний хугацааг 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдөр хүртэл сунгасан.Өөрчлөлтийн ажлын зураг, төсвийг Барилгын хөгжлийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 27-ны 2274/2023 дугаартай магадлалын нэгтгэсэн дүгнэлтээр батлуулсан

Дараах барилгын ажлыг бүрэн гүйцэтгэн улсын комиссыг ажлуулан зарим барилгын ажлуудыг холбогдох ашиглагч байгууллагад хүргүүлээд байгааг дараах хүснэгтэд тусгав.

№	Барилгын ажлын нэр	Улсын комисс ажилласан огноо	Хөрөнгөд бүртгэсэн огноо/ захирамж дугаар
АХБ-ны санхүүжилт			

№	Барилгын ажлын нэр	Улсын комисс ажилласан огноо	Хөрөнгөд бүртгэсэн огноо/ захирамж дугаар
1	GWD11: Хөрсний ус зайлуулах шугам - Үе шат 1	10/12/2020 № ИС-63/2020	Геодез усны байгууламжийн газарт хүргүүлэхээр бичиг баримтыг бэлтгэж байна
2	GWD14: Хөрсний ус зайлуулах шугам - Үе шат 2	10/30/2020 № ИС-89/2020	
3	BHF06B: Баянхошуу дэд төв хүртэлх дулааны шинэ шугам, 3.0 км	02/08/2021 № ИС-028/2021	2 УДДТ-ыг орон сууц нийтийн үйлчилгээний газарт 5.8км дулааны сүлжээ, насос станцыг Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК 4 хаалттай дэд өртөөг Улаанбаатар цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК
4	SHS: 126 айлын орон сууцны барилга	8/2/2023 БА-133/2023	2024.04 сард Нийслэлийн орон сууцны корпораци (НОСК) актаар хүлээлгэж өгсөн
ЕХОБ-ны санхүүжилт			
6	WSC16B: Шархад дэд төвийн Цайз эко хотхон хорооллыг төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын шугам, халуун, дулааны шугам, болон цахилгаан хангамжийн шугамд холбох зураг төсөл, ханган нийлүүлэлт, угсралтын ажил	8/23/2021 Цах-176/2021 11/1/2021 ИС-219/2021	Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК
7	HSSC-B: Сэлбэ дэд төвийн 2 дугаар хэлхээний шугам сүлжээний угсралтын ажил	2021.12,15 ИС-246/2021	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ
8	USF: Морингийн даваа орчмын шинэ суурьшлын бүсийг инженерийн хангамжийн шугам сүлжээнд холбох	10/22/2022 2/27/2023 ХАХО-002/2023	Ус Сувгийн Удирдах Газар Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК
9	HSSC-D: Сэлбэ дэд төвийн 2 дугаар хэлхээний шугам сүлжээний угсралтын ажил	9/12/2022 ИС-007/2022	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ

Хүснэгт 11 Барилгын ажлын явц

Дээрх хүлээлгэн өгсөн барилгуудын ажлаас дараах үр дүн гарч байна.

- Сэлбэ дэд төвийн 4.1 км хөрсний ус зайлуулах шугам хоолойн барилга угсралтын ажлыг гүйцэтгэснээр хөрсний усны түвшин доошилж тухайн хэсэгт Хөтөлбөрийн 1-р үе шатны хүрээнд хийгдэж байсан инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил бүрэн хийгдэж дууссан.
- Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаан хангамжид холбох, дулааны даралт өргөх, насос станц, ус дулаан дамжуулах төв, дулааны шинэ шугамын зураг төсөл, ханган нийлүүлэлт, угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр дараах үр дүн гараад байна. Үүнд:
 - Дулааны 11и магистраль шугам хоолойг өргөтгөж, шинэчлэх ажлыг хийснээр Ханын материал, Баянхошуу орчмын барилга байгууламж, хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох нөхцөл бүрдэж, шинээр дулааны магистраль шугам Баянхошуу дэд төв рүү татах боломж үүссэн.

БҮРЭЛДЭХҮҮН 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ

Энэ бүрэлдэхүүн хэсгийн зорилго нь төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж барилгын ажлуудтай холбоотой болон хот төлөвлөлт, дэд төвүүдийн хөгжлийг боловсронгуй болгох, дэд төвийн бүтээн байгуулалтын талаарх иргэдийн ойлголтыг төлөвшүүлэх, тэдний оролцоог хангах, дэд бүтцийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаа, менежментийг сайжруулах замаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавхыг дээшлүүлэх юм.

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна

9.1.1.4. АХБ-НЫ ХАМГААЛЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

■ ГАЗАР ЧӨЛӨӨЛӨЛТ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН АЖЛЫН ЯВЦ

Төслийн II үе шатны газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн хамрах хүрээний бичиг баримт 1, газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн 6 төлөвлөгөө, 10 зохистой байдлын тайлан боловсруулж АХБ-аар баталгаажуулсан. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө болон зохистой байдлын тайланг боловсруулахад тухайн сонгосон байршил болон амьдарч буй иргэдтэй зөвлөлдөх уулзалтууд хийх болон нөлөөлөлд өртөх магадлалтай иргэдээс нийгэм эдийн засгийн судалгаа авч тайлангийн хугацаанд 99,4%-д хүрсэн байна.

Дэнжийн 1000 дэд төвийн дулааны станцын газар чөлөөлөлт

Төсөл хөтөлбөрийн II үе шат Дэнжийн мянга дэд төвийн дулааны станцын байршилыг СБД-ийн 9-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжүүлэхээр Эрчим хүчний яамны шинжлэх ухаан технологийн зөвлөлийн шийдвэр гарсан ба сонгогдсон байршилд нийт 84 нэгж талбар өртөж байсан ба үүнээс 2016-2018 онд Нийслэлийн орон сууцны бодлогын газар (НОСБГ)-аас 26, 2022-2024 онд НГЗБА-аас 45 нэгж талбар нийт 71 нэгж талбарыг чөлөөлөөд байна.

Газар чөлөөлөлтийн ажлын явц 85%-тай үргэлжилж байгаа бөгөөд шаардлагатай төсвийг НЗДТГ-ын 2025 оны төсөвт тусгаж, үлдсэн 13 нэгж талбарыг чөлөөлөхөөр зөвшилцлийн ажил хийгдэж байна.



Зураг 6 Дэнжийн 1000 дэд төвийн Дулааны станцын байршил

Дамбадаржаа болон Баянхошуу дэд төвийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд нөлөөлөлд өртсөн нийт 349 иргэн, хуулийн этгээд нөхөн олговроо авсан ба үүнээс газар өмчлөгч, эзэмшигч эрхтэй 234 иргэн, хуулийн этгээдээс нөлөөлөлд бүтэн өртсөн 205 иргэний гэрчилгээг хүчингүй болгуулахаар холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгч ҮХХ-ийн хувийн хэргийг хаалгасан, хэсэгчлэн өртсөн 24 өрхийн газрын гэрчилгээ болон кадастрын зурагт өөрчлөлт оруулахаар холбогдох материалуудыг бэлтгэн НГЗБА, ДУБХ-т хүлээлгэн



Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

өгч, хамтран ажиллаж тэдгээр иргэн, хуулийн этгээдүүдийн газрын гэрчилгээ болон кадастрын зургийг өөрчлөн хүлээлгэн өгсөн байна.

Тайлант хугацаанд Дамбадаржаа дэд төвийн ариутгах татуургын ажлын трасс батлагдсан зургаараа хийгдэхээр болсон тул тоон хэмжээнд өөрчлөлт орсон.

Төслийн II үе шатны газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртсөн нийт 351 иргэн хуулийн этгээдээс 349 иргэн хуулийн этгээдийн 20,223,092,258 төгрөгийн санхүүжилт хийгдсэн.

№	Санхүүжүүлэгч	Нөхөн олговрын дүн
1	НЗДТГ-ын төсөв	1,835,298,742.00
2	АХБ-ны зээл	18,387,793,516.00
	Нийт	20,223,092,258.00

Хүснэгт 12 Нөхөн олговрын мэдээлэл

Үе шат 2-ын газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн хувьд дараахи 2 нэгж талбартай хэлэлцээр хийгээгүй байна.

Үүнд:

- Баянхошуу дэд төвийн: *Гал унтраах 29-р анги болон спортын гадна шугам сүлжээний ажлын 1 айл нь газар дээрээ амьдардаггүй хоосон тул хэлэлцээр хийгдээгүй. (Газар өмчлөгчтэй холбогдох боломжгүй байгаа)*
- Дамбадаржаа дэд төвийн: *Авто зам инженерийн барилга байгууламжийн ажлын 1 өрх эд хөрөнгийн маргаантай тул шүүхдэж байгаа тул хэлэлцээр хийгдээгүй*

Ажлын нэр	ГЧ Төлөвлөсөн				ГЧ-ийн гүйцэтгэл 2024 оны 12 сарын байдлаар				
	Нийт НӨ нэгж талбар	НӨ хэлбэр		НӨ иргэн, хуулий н этгээд	Нийт НӨ нэгж талбар	НӨ хэлбэр		НӨ иргэн, хуулийн этгээд	Санхүүжилт авсан иргэн, хуулийн этгээд
		Бүтэн	Хагас			Бүтэн	Хагас		
А. Баянхошуу дэд төв									
Цэцэрлэг болон ОНХТ-ийн барилгынажил	1	1	0	1	1	1	0	1	1
Үерийн далангийн ажил	24	7	17	24	24	7	17	24	24
Гал унтраах 29-р анги болон спортын гадна шугам сүлжээний ажил	20	10	10	23	24	12	12	27	26
Нийт (А)	45	18	27	48	49	20	29	52	51
Б. Дамбадаржаа дэд төв									
Цэцэрлэг болон мэдээлэл технологийн барилгын ажил	12	12	0	17	12	12	0	17	17
Дулааны станц	41	41	0	50	41	41	0	50	50
Авто зам инженерийн барилга байгууламжийн ажил	130	127	3	202	129	126	3	202	201
Ус зайлуулах хоолой, үерийн усны хоолой болон холбоо, цахилгааны шугмын ажил	6	0	6	6	5	0	5	5	5
Дулааны станцаас дэд төв хүртэлхи дулааны шугмын ажил	19	6	13	24	15	6	9	20	20
Ариутгах татуургын ажил	0	0	0	0	2	1	1	3	3
Нийт (Б)	208	186	22	299	204	186	18	297	296
В. Бусад дэд төв									
Сэлбэ дэд төвийн ариутгах татуургын ажил	0	0	0	0	1	1	0	1	1
Шархад дэд төвийн Цайз ЭКО хотхоны УДДТ-ийн барилгын ажил	1	1	0	1	1	0	1	1	1
Нийт (В)	1	1	1	1	2	1	1	2	2
Нийт дүн	254	205	50	348	255	207	48	351	349

Хүснэгт 13 Төслийн 2 үе шатны газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн мэдээлэл

■ НИЙГЭМ БОЛОН ЖЕНДЕР, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024 оны 4 дүгээр улирлын байдлаар төслийн II үе шат, Нийгмийн хамгаалал, жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөний нийт хэрэгжилт 63.4%, 2024 оны ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 90% гүйцэтгэлтэй байна.

Төслийн II үе шат, Дамбадаржаа дэд төвд дараах үйл ажиллагаануудыг зохион байгууллаа. Үүнд:

Тайлангийн хугацаанд Дамбадаржаа, Баянхошуу дэд төвийн иргэд, хороодын албан хаагчид, бүлгийн ахлагч нарт төслийн явцын мэдээлэл өгөх 6 удаагийн уулзалтыг 192 (124 буюу 64.6% эмэгтэй) оролцогчтойгоор зохион байгууллаа. Мөн дэд төвийн иргэд, хүүхэд залуус, эмзэг зорилтот бүлгийн иргэд, гүйцэтгэгч компанийн ажилчдад чиглэсэн 5 төрлийн 58 удаагийн чадавхжуулах сургалтыг зохион байгуулж 807 оролцогчид хамрагджээ. Эдгээр оролцогчдын 314 буюу 38.9% нь эмэгтэй байсан. Түүнчлэн төслийн нэгжийн албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор 5 удаагийн сургалтыг давхардсан тоогоор 108 ажилтнуудад зохион байгууллаа.

• Төслийн явцын мэдээлэл хүргэх уулзалт

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн II үе шат болох Дамбадаржаа, Баянхошуу дэд төвүүдийн иргэд, бүлгийн ахлагчид, хороодын албан хаагчдад төслийн явцын мэдээ хүргэх 6 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг 2024 оны 5, 9, 11, 12 дугаар саруудад зохион байгуулав. Уулзалтаар төслийн явц, барилга угсралтын ажлуудын явцын танилцуулга, ХАБЭА зааварчилгаа, аюулгүй байдлын зөвлөмж, төслийн нийгэм жендерийн төлөвлөгөөний хүрээнд хэрэгжиж буй ажлууд, санал гомдлын механизм болон олон нийтийн оролцоотой хяналт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх зөвлөмж зэрэг олон талын мэдээллийг өгч, санал солилцов. Түүнчлэн, Дамбадаржаа дэд төвд баригдах Дулааны станцын ажил эхлэхтэй холбогдуулан Чингэлтэй дүүргийн 19-р хорооны иргэд, хорооны ажилтнууд, хэсгийн ахлагч нарт зориулсан мэдээлэл солилцох уулзалтыг мөн зохион байгууллаа. Энэхүү үйл ажиллагаа нь иргэдийн мэдээлэл авах, оролцоог нэмэгдүүлэх, аюулгүй байдлыг хангах, төслийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэн ажилласан.

Иргэдийг мэдээллээр бүрэн хангах зорилгоор барилга угсралтын ажлуудын танилцуулга хуудас бүхий мэдээллийн багцыг боловсруулан уулзалтад оролцогчид, дэд төвүүдийн олон нийтийн газрууд буюу худаг дэлгүүрт, мөн Дамбадаржаа дэд төвийн зам инженерийн шугам сүлжээний дагуух айл өрхүүдэд нийт 1000 орчим ширхэгийг түгээн ажиллалаа.



Зураг 7 Олон нийтийн уулзалтуудын явцаас



Зураг 8 Мэдээллийн хуудсыг худаг, дэлгүүрүүдээр байршуулав

Чадавхжуулах сургалт хөтөлбөр

2024 онд Дамбадаржаа дэд төвийн иргэд, хүүхэд залуус, эмзэг зорилтот бүлгийн иргэд, гүйцэтгэгч компанийн ажилчдад чиглэсэн 5 төрлийн 58 удаагийн чадавхжуулах сургалтыг зохион байгуулж нийт 807 оролцогчид хамрагджээ. Эдгээр оролцогчдын 314 буюу 38.9% нь эмэгтэй байсан. Үүнд:

1. Нийтийн болон хувийн орон зай дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх; Хорт зуршлаас сэргийлэх мэдлэг олгох сургалт

Дамбадаржаа дэд төвийн зорилтод бүсийн 58-р сургуулийн ахлах, дунд ангийн сурагч охид, хөвгүүд болон Сүхбаатар дүүргийн сурагчдын зөвлөлийн гишүүдэд нийтийн ба хувийн орон зайд гарч болох хүчирхийлэл, дарамт, үе тэнгийн хүүхдүүдийн дээрэлхэлтийн учир шалтгаан, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх арга замын талаар мэдлэг, мэдээлэл өгөх зорилгоор “Нийтийн болон хувийн орон зай дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох нь” сэдэвт 8 удаагийн сургалтыг “Хөөрхөн зүрх” ТББ-тай хамтран зохион байгууллаа. Энэхүү сургалтуудад нийт 268 сурагчид хамрагдсанаас 128 охид оролцсон байна. Сургалтаар нийтийн ба хувийн орон зай, түүний хүрээ, цахим орчин дахь хүчирхийллийн төрлүүд, түүнээс урьдчилан сэргийлэх аргуудын талаар ойлголт өгч, өөрт болон ойр дотны найз нөхөд, гэр бүлийн насанд хүрээгүй гишүүдэд эрсдэл тохиолдоход насанд хүрсэн итгэж болох хүнээс тусламж авах зэрэг оновчтой аргуудын тухай ярилцлаа. Дээрх сургалтуудын үеэр үерхэл, нөхөрлөлийн харилцааны талаар болон аливаа харилцаанд хил хязгаарыг тогтоосноор хувийн орон зайгаа хэрхэн хамгаалдаг, эрүүл харилцаа үүсгэхэд энэ нь хэрхэн тусалдаг, бусад хүмүүсийн хүсэл, сонирхолд хүндэтгэлтэй хандахын зэрэгцээ өөрийн хүсэл, хэрэгцээ, үйлдэлдээ хариуцлагатай байж, бусад хүмүүс чамайг удирдах, дарамтлах, зохисгүй байдлаар харилцахаас хэрхэн сэргийлж чадах талаар ойлголт, мэдээлэл өглөө. Мөн хүүхдүүдийг хорт зуршлаас сэргийлэх арга замын талаар мэдээлэл сургалтыг “Зөв дадал” ТББ-тай хамтран өгөв.



Зураг 9 Сургалтын явцаас

2. УБХГХХХОДХ төслийн дэд төвийн нэн ядуу, бага орлоготой, эмзэг бүлгийн иргэдийг дэмжих хөтөлбөр-“Архины хамаарлын эсрэг сургалт, нөлөөллийн ажил” төсөл

Дамбадаржаа дэд төвийн архины хамааралтай, орлого багатай иргэдэд зориулсан хөдөлмөр заслын сэтгэл зүйн үйлчилгээ, сургалт нөлөөллийн ажлыг 2024 оны 1-р сараас 5-р сар хүртэл хугацаанд Сүхбаатар дүүргийн Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэс, Цагдаагийн 2-р хэлтэс, 15, 16, 17-р хорооны Засаг даргын ажлын алба, Нийслэлийн ерөнхий боловсролын 58-р сургууль, “Зөв дадал” ТББ-тай хамтран хэрэгжүүлээ. Хөтөлбөрийн зорилго нь дэд төвийн нэн ядуу, бага орлоготой, эмзэг бүлгийн буюу архины хамааралтай иргэд, тэдний гэр бүлийн гишүүдийг архины хамаарлын эсрэг сэтгэл засал, хөдөлмөр эмчилгээний сургалтад хамруулан, архины хэрэглээнээсээ татгалзах, амьдралын зөв дадал, зуршилтай болоход нь дэмжлэг үзүүлснээр эдгээр өрхийн амьжиргаа сайжирч, эмэгтэйчүүд, хүүхдүүдийн аюулгүй байдал хангах юм. Хөтөлбөрийн хүрээнд 40 удаагийн хөдөлмөр засал, бүлгийн сургалтыг зохион байгуулж 205 хүн (72 эмэгтэй) хамрагдлаа. Хөтөлбөрийн үр дүнд 25 иргэн архины хэрэглээнээс татгалзаж, 6 иргэн байнгын ажлын байртай болж, Хүүхэд хамгааллын төвд (108) байрлаж байсан 3 хүүхэд эцэг эхийн асрамж руу шилжив. Энэхүү нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх хугацаанд Дамбадаржаа бүс нутагт гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн гаралт 27%-иар буурсан гэж цагдаагийн 2-р хэлтсээс мэдэгдлээ.



Зураг 10 Хөтөлбөрийн явцаас

3. Төслийн гэрээт гүйцэтгэгч компанийн ажилтнуудад эрүүл мэнд, ХДХВ/ДОХ болон БЗХӨ-с урьдчилан сэргийлэх сургалт

Тайлангийн хугацаанд Дамбадаржаа дэд төвийн барилгын гэрээт гүйцэтгэгч 5 компаниуд (“Янчэнг шингуо констракшн инженеринг”, “Монхас”, “Ванхүү”, “Стандарт Холдинг”, “Голомт констракшн”, “Аглут” ХХК) нь ХДХВ/ДОХ болон бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх, жендерт суурилсан хүчирхийлэл, ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгууллаа. Нийт 123 ажилтнууд хамрагдсанаас 19 буюу 15.4% нь эмэгтэй ажилтнууд байв.



Зураг 11 Эрүүл мэндийн сургалтын явцаас

4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалт

Тайлангийн хугацаанд Дамбадаржаа дэд төвд замын хөдөлгөөний аюулгүй байдал, түүнээс урьдчилан сэргийлэх сэдвээр нийт 5 сургалтыг 158 оролцогчтойгоор (80 буюу 50.6% эмэгтэй) зохион байгууллаа. 2024 оны 11-р сард дэд төвийн 49 иргэнд (32 эмэгтэй) 2 удаагийн танилцуулга сургалт зохион байгуулсан. 2024 оны 12-р сард тус дэд төвд байрлах 175, 159, 205-р цэцэрлэгийн 109 хүүхэд багачуудад (48 охид) зориулан 3 удаагийн сургалт явуулсан. Эдгээр сургалтаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлж, хүүхэд, иргэдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээллээр хангав.

5. Гэрээт гүйцэтгэгч компаниудын ажилтнуудад “Жендерийн тэгш байдал, хөдөлмөрлөх эрх, ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалт.

Төсөл хэрэгжүүлэх нэгжээс төслийн гэрээт гүйцэтгэгч нарт зориулан “Жендерийн тэгш байдал, хөдөлмөрлөх эрх, ажлын байран дахь бэлгийн дарамтын ойлголт болон түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг 2024 оны 3-р сард зохион байгуулав. Сургалтад нийт 27 барилгын компанийн удирдлага, инженер техникийн ажилчид хамрагдлаа. Сургалтаар авлигал албан тушаалын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай ойлголт, Азийн хөгжлийн банкны нийгмийн хамгааллын бодлого, хөдөлмөрийн эрх, хөдөлмөрийн харилцаан дахь жендерийн тэгш байдлыг хангах, барилгын салбарт баримталж буй жендерийн бодлого, жендерийн мэдрэмжтэй төлөвлөлтийн талаар болон ажлын байран дахь бэлгийн дарамтын талаарх ойлголтыг өгч, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаар мэдлэг, мэдээлэл өгсөн.



Зураг 12 Сургалтын явцаас

• Гэрээт гүйцэтгэгч компаниудад “Барилгын явцад эмэгтэй болон тусгай хэрэгцээт хүмүүст ээлтэй ажиллах орчныг хэрхэн бүрдүүлсэн эсэх” талбайн хяналт

Тайлангийн хугацаанд нийгмийн болон жендерийн баг төслийн 2 дугаар үе шатны 8 гүйцэтгэгчийн ажлын талбайгаар айлчилж барилгын явцад эмэгтэй болон тусгай хэрэгцээт хүмүүст ээлтэй ажиллах орчныг хэрхэн бүрдүүлсэн эсэх хяналтыг хийж гүйцэтгэлээ. Хяналтаар 8 гүйцэтгэгч бүгд ажилтнуудтайгаа хөдөлмөрийн гэрээ байгуулж, үйл ажиллагааны журам, хүний нөөцийн бодлого болон хөдөлмөрийн дотоод журмуудыг жендертэй холбоотой заалтууд, тухайлбал эмэгтэйчүүдийн хөхүүл хүүхэд асрах хугацаа болон чөлөөний бодлого зэргийг тусган боловсруулсан байна.

• Бусад үйл ажиллагаа:

АХБ-ны Иргэний нийгмийн байгууллагын түншлэлийн өдөрлөгт оролцов.

- “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн нийгэм жендер, олон нийтийн оролцооны багийн зүгээс 2024 оны 9-р сард АХБ-ны зохион байгуулсан “Иргэний нийгмийн байгууллагын түншлэл”-ийн өдөрлөгт

оролцож, төслийн зорилго үйл ажиллагааны танилцуулгыг өдөрлөгт оролцогчдод танилцуулан ажиллав.



Зураг 13 Өдөрлөгийн явцаас

- АХБ-ны “Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, дарамт” (SEAH) бичиг баримт боловсруулалтын ажилд дэмжлэг үзүүлэн бичиг баримтын бүрдүүлэлт, журам, санал гомдлын механизм, гарын авлага зэрэгт санал зөвлөмжийг боловсруулж, өөрсдийн саналыг танилцуулах уулзалтыг 2024 оны 9 сард зохион байгууллаа.
 - Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудыг чадавхжуулах ажлын хүрээнд дараах сургалтуудыг 2024 оны 1-р улиралд зохион байгуулав.
- Жендерийн тухай ойлголт, жендерийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны бэлгийн дарамт, авлигал, албан тушаалын зөрчлийн тухай ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам сэдэвт сургалтад 30 ажилтан хамрагдлаа.
- “Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуй” сэдэвт сургалтад төсөл хэрэгжүүлэх нэгжийн 26 албан хаагчид хамрагдав. Сургалтаар аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалан ажиллах шаардлагатай хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)-н суурь болон хууль эрх зүйн ойлголт өгөв.
- “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан шинэчилсэн найруулгын танилцуулга сургалтыг төсөл хэрэгжүүлэх нэгжийн 32 албан хаагчдад зохион байгууллаа.
- АХБ-ны хамгааллын бодлогын баримт бичгийн танилцуулга сургалтыг зохион байгуулж, ТХН-ийн 8 мэргэжилтэн хамрагдлаа.
- АХБ-ны худалдан авах ажиллагааны журмын баримт бичгийн танилцуулга сургалтыг зохион байгуулж, ТХН-ийн 9 мэргэжилтэн оролцов.

9.1.1.5. САНХҮҮЖИЛТ

Эх үүсвэр	Санхүүжилт	Эзлэх хувь	Зарцуулалт	%
АХБ-ны санхүүжилт				
COL зээл	29.24	23.09%	25.83	88.34%
OCR зээл	37.11	29.30%	28.17	75.91%
Дэд дүн	66.35	52.38%	54	81.39%
НЗДТГ-ын төсөв	40.67	32.11%	15.01	36.91%
ЕХОБ-ны санхүүжилт	19.64	15.51%	15.22	77.49%
Нийт	126.66	100.00%	84.23	66.50%

Хүснэгт 14 Санхүүжилтийн зарцуулалт

9.1.2. ХӨТӨЛБӨРИЙН ГУРАВ ДУГААР ҮЕ ШАТ

9.1.2.1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хөтөлбөрийн III үе шатны хүрээнд (i) Хотын зүүн хэсгийн гэр хорооллын Шархад, Толгойт дэд төвүүдийн дэд бүтцийг шинэчлэх, орон зайн бүтцийн өөрчлөлт хийж бусад дэд төвүүдтэй холбоно, (ii) нийгэм эдийн засгийн барилга байгууламж барих, (iii) чадавх бэхжүүлэх үйл ажиллагаануудыг хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн 3-р үе шатны дэд төвүүдээс нийт 15,799 хүн (4,329 өрх) үр шим хүртэнэ. Үүнээс Толгойт дэд төв буюу Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 3, 34 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 153 га талбайд 6,860 хүн 1846 өрх, Шархад дэд төв буюу Баянзүрх дүүргийн 8, 9, 10, 17, 19, 24 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 124 га талбайд 8,939 хүн, 2483 өрх амьдарч байна.

Үе шат III-ын зээлийн хэлэлцээрийг 2020 оны 12 сарын 30-нд батлуулсан.

Төслийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

/сая ам.доллараар/		
Эх үүсвэр	Санхүүжилт	Эзлэх хувь
АХБ-ны санхүүжилт		
МОН-3946 (COL)	18.60	24.00
МОН-3947 (OCR)	25.05	32.32
Дэд дүн	43.65	56.32
НЗДТГ-ын төсөв	15.21	19.62
ЕХОБ-ны санхүүжилт FI'83873	18.65	24.06
Нийт	77.51	100.00

Хүснэгт 15 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

№	Үндсэн үйл ажиллагаа	Төлөвлөсөн
А. Суурь зардал		94.40
I	Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх	77.06
1.1	Автозам сайжруулах	50.92
1.2	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, үйлчилгээг сайжруулах	15.34
1.4	Дулааны шугам сүлжээ, үйлчилгээг сайжруулах	10.80
II	Эдийн засгийн болон нийгмийн байгууламжийг нэмэгдүүлэх	14.05
III	Байгууллагыг чадавхжуулах	3.29
Б. Магадалшгүй ажил		16.62
В. Хэрэгжүүлэх үеийн санхүүгийн хураамж		3.18
Нийт дүн		114.20

Хүснэгт 16 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

Хөтөлбөрийн III үе шатыг дараах бүрэлдэхүүн хэсгүүдээр хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх
2. Нийгэм, эдийн засгийн барилга байгууламжууд
3. Төсөл хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх

Хөтөлбөрийн III үе шатны хүрээнд Толгойт, Шархад дэд төвүүдийн бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэж байна. II үе шатны хэрэгжилтийн явц 38.9% байна.

Үйл ажиллагаа	Бодит явц
Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлт	87.28%
Төлөвлөлт	100.00%
Хэрэгжүүлэлт	83.74%



Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

Зураг төсөл боловсруулалт	73.45%
Худалдан авах ажиллагаа	38.64%
Барилгын ажил	39.95%
Зөвлөх үйлчилгээ	60.81%
Бараа	0%
Барилга угсралт	15.86%
Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх	12.84%
Нийгэм, эдийн засгийн барилга байгууламжууд	22.41%
Зөвлөх үйлчилгээ	75.73%
Нийт	38.91%

Хүснэгт 17 3 дугаар үе шатны хэрэгжилтийн явц

9.1.2.2. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 12 сард шинэчлэгдэн батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 9 дэх хувилбарт нийт 36 барилгын ажил, 4 бараа, 8 зөвлөх үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулахаар төлөвлөснөөс 12 барилгын ажил, 7 зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулаад байна.

Одоогийн байдлаар дараах 14 ажлуудын худалдан авалтын үйл ажиллагааг гүйцэтгэж байна.

№	Ажлын нэр	Худалдан авалтын явц
ЗАРЛАСАН ХАА		
1	SHTL-A: Толгойт дэд төвийн тохижилт, ногоон байгууламжийн ажил (байршил 1)	- Төслийн дуусах хугацаа, тохижилтийн ажлын тендер оролцогчгүй байгаа зэргийг харгалзан төслийн санхүүжүүлэгч АХБ-аас тус ажлыг төсөл дээр одоо гэрээт ажил гүйцэтгэж буй барилга угсралтын компаниудтай зөвшилцөн гэрээний нэмэлт өөрчлөлтөөр гүйцэтгүүлэхийг зөвшөөрсний дагуу тухайн дэд төвд барилга угсралтын ажил гүйцэтгэж буй төслийн гүйцэтгэгч компаниас тус ажлыг гүйцэтгэх үнийн саналыг хүлээн авсан. Гэрээний нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулж байна.
2	SHTL-B – Толгойт дэд төвийн тохижилт, ногоон байгууламжийн ажил (байршил 2)	- Энэхүү тендер шалгаруулалтыг дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалтын аргаар 2 удаа, гэрээ шууд байгуулах аргаар 1 удаа тус тус 2023 онд зохион байгуулж, амжилтгүй болсон - Төслийн дуусах хугацаа, тохижилтийн ажлын тендер оролцогчгүй байгаа зэргийг харгалзан төслийн санхүүжүүлэгч АХБ-аас тус ажлыг төсөл дээр одоо гэрээт ажил гүйцэтгэж буй барилга угсралтын компаниудтай зөвшилцөн гэрээний нэмэлт өөрчлөлтөөр гүйцэтгүүлэхийг зөвшөөрсний дагуу тухайн дэд төвд барилга угсралтын ажил гүйцэтгэж буй төслийн гүйцэтгэгч компаниас тус ажлыг гүйцэтгэх үнийн саналыг хүлээн авч, АХБ-наас гэрээний нэмэлт өөрчлөлтийн зөвшөөрлийг 2024 оны 11 сарын 25-нд олгосон.
3	TBCF: Толгойт дэд төвийн сургалтын төвд тоног төхөөрөмж худалдаж авах	- Тендерийг 2024 оны 12 сарын 20-ны өдөр зарласан.
4	ТЕС-В: Толгойт дэд төвд баригдах цахилгааны дэд станц	- Энэхүү тендер шалгаруулалтыг 2023 онд нэг удаа зарлаж, амжилтгүй болсон.

№	Ажлын нэр	Худалдан авалтын явц
	(10Кв цахилгаан түгээх кабель шугам)	- 2024 оны 08 сарын 13-нд дахин зарлаж, 2024 оны 09 сарын 13-нд хаасан ба нийт 9 компани ТББ-г худалдан авснаас 1 компани саналаа ирүүлсэн. - Үнэлгээний тайланг АХБ-нд 12 сарын 27-ны өдөр хүргүүлсэн.
5	ТЕС-С: Толгойт дэд төвийн хуваарилах байгууламжууд, 10кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугамын ажил	- Энэхүү тендер шалгаруулалтыг 2023 онд нэг удаа зарлаж, амжилтгүй болсон. - 2024 оны 08 сарын 22-нд дахин зарлаж, 2024 оны 10 сарын 07-нд хаасан. - Нийт 3 компани саналаа ирүүлсэн. - Үнэлгээний тайланг эцэслэж байна.
6	TRDH14-A - Толгойт дэд төвийн авто зам, инженерийн шугам сүлжээний ажил (үе шат 1)	- Тендерийг 2023 оны 10 сарын 19-ний өдөр нээсэн. - Тендерийн үнэлгээний тайланд АХБ-аас зөвшөөрлийг 2024 оны 10 сарын 25-нд ирүүлсэн - Толгойт дэд төвийн төлөвлөлтийн Б хэсгийн 11Гкал/ц дулааны техникийн нөхцөл Эрчим Хүчний Яамнаас олгогдохгүй хугацаа алдсаны улмаас дулаан хангамжийн зураг төсөл Барилга хөгжлийн төвөөр батлагдаагүй байсан тул зураг төсөл батлагдахыг хүлээж байна. .
ЗАРЛАХААР ТӨЛӨВЛӨСӨН		
7	ТЕС-А: Толгойт дэд төвийн холбооны шугам сүлжээний ажил	- Энэхүү тендер шалгаруулалтыг 2023 онд нэг удаа зарлаж, амжилтгүй болсон. - Зураг төсөл батлагдахаар 2025 оны 1 сард дахин зарлахаар төлөвлөж байна.
8	TRDH14-B - Толгойт дэд төвийн авто зам, инженерийн шугам сүлжээний ажил (үе шат 2) (дахин зар)	- Энэхүү тендер шалгаруулалтыг 2023 онд дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалтын аргаар 2 удаа зохион байгуулж амжилтгүй болсон - Өөрчлөгдсөн зураг төсөл батлагдахаар 2025 оны 1 сард дахин зарлахаар төлөвлөж байна.
9	TRDH11-A: Толгойт дэд төвд хийгдэх ариутгах татуургын шугам суурилуулалтын ажил	- Зураг, төсвийг шинэчилж байна. Зураг төсөл батлагдахаар 2025 оны 2 сард дахин зарлахаар төлөвлөж байна.
10	TRDH11-B: Толгойт дэд төвийн авто замын ажил	- Зураг, төсвийг шинэчилж байна. Зураг төсөл батлагдахаар 2025 оны 1 сард дахин зарлахаар төлөвлөж байна..
11	SHTL-C1 - Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар хорооны 50 айлын орон сууцны барилгын урд талбайн бичил тохижилт болон Сонгинохайрхан дүүргийн 9 дүгээр хороонд 3х3 сагсан бөмбөгийн талбайн тохижилт	- Эхний удаагийн тендер шалгаруулалтад нэг ч тендер ирээгүй - Төслийн дуусах хугацаа, тохижилтийн ажлын тендер оролцогчгүй байгаа зэргийг харгалзан төслийн санхүүжүүлэгч АХБ-аас тус ажлыг төсөл дээр одоо гэрээт ажил гүйцэтгэж буй барилга угсралтын компаниудтай зөвшилцөн гэрээний нэмэлт өөрчлөлтөөр гүйцэтгүүлэхийг зөвшөөрсний дагуу тухайн дэд төвд барилга угсралтын ажил гүйцэтгэж буй төслийн гүйцэтгэгч компаниас тус ажлыг гүйцэтгэх үнийн саналыг хүлээн авч, АХБ-наас гэрээний нэмэлт өөрчлөлтийн зөвшөөрлийг 2024 оны 11 сарын 25-нд олгосон.
12	SHTL-C2- Сонгинохайрхан дүүргийн 10 дугаар хороонд бичил тохижилтын ажил	- Эхний удаагийн тендер шалгаруулалтад шаардлага хангасан нэг ч тендер ирээгүй. - Зураг төсөл эцэслэгдэж байна

№	Ажлын нэр	Худалдан авалтын явц
13	SHTL-C3- Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар хороо, Нийслэлийн 261 дүгээр цэцэрлэгийн гадна нэмэлт авто зогсоолын ажил	- Эхний удаагийн тендер шалгаруулалтад нэг ч тендер ирээгүй - Зураг төсөл эцэслэгдэж байна
14	SHTL-C4- Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар хороо, Бизнес инкубатор төвийн гадна нэмэлт авто зогсоолын ажил	- Эхний удаагийн тендер шалгаруулалтад нэг ч тендер ирээгүй - Зураг төсөл эцэслэгдэж байна

Хүснэгт 18 Худалдан авалтын явц

Худалдан авалтын төлөвлөгөөнд нийт 11 багц ажил 1 зөвлөх үйлчилгээний ажлыг НЗДТГ-ын санхүүжилтээр хийхээр төлөвлөсөн боловч тухайн ажлуудад 2024 онд төсөв хувиарлаагүй тул энэхүү ажлууд зогсонги байдалтай байна. Үүнд дараах ажлууд багтсан байна.

Шархад дэд төвд

- Цахилгааны шугам 10.9 км
- Холбооны шугам 2.7 км
- Мэдээлэл холбооны төв
- Үерийн далан суваг 2 км
- Бохир усны шугам 4 км
- Цэвэр усны шугам 7.1 км
- Дулааны шугам 11.6 км
- Авто зам 6 км
- 240 Хүүхдийн цэцэрлэг
- Олон нийтийн хөгжлийн төв
- Спорт цогцолбор
- Бизнес инкубатор, сургалтын төв
- 1000м3 усан сан

Худалдан авалтын үйл ажиллагааны явц 38.64%-тай байна.

Энэхүү үе шатны хүрээнд байгуулсан гэрээний хэрэгжилтийн мэдээллийг Хавсралт 6-д үзүүлэв

9.1.2.3. БАРИЛГЫН АЖЛЫН ЯВЦ

Барилгын ажлын дэлгэрэнгүй мэдээллийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр дараах байдалтай байна.

БҮРЭЛДЭХҮҮН 1. АВТО ЗАМ БОЛОН ХОТЫН ҮНДСЭН ҮЙЛЧИЛГЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 8 барилгын ажил үргэлжлэн хийгдэж байна.

№	Багцын дугаар	Ажлын нэр	Ажлын тоо хэмжээ	Ажлын явц	
				2023. 12.30	2024. 12.30
АХБ-ны санхүүжилт					

№	Багцын дугаар	Ажлын нэр	Ажлын тоо хэмжээ	Ажлын явц	
				2023. 12.30	2024. 12.30
1	SC-A	Барилгын талбарын байгаль орчны ариутгал, халдваргүйжүүлэлт, хог хаягдлыг цэвэрлэх тээвэрлэх, нөхөн сэргээлт хийх 1-р хэсгийн ажил	Айл өрхийн байшин болон байгууламжийг нураах, буулгах мөн хог хаягдлыг ачих 0.25м3 багтаамжтай шанагат экскаватораар нүхэн жорлонгийн бохирыг ухаж самосвалд ачих хуучин 00 халдваргүйжүүлэх Талбайг тэгшлэх	100%	100%
2	SC-B	Барилгын талбарын байгаль орчны ариутгал, халдваргүйжүүлэлт, хог хаягдлыг цэвэрлэх тээвэрлэх, нөхөн сэргээлт хийх 2-р хэсгийн ажил	77 нэгж талбарт цэвэрлэгээ хийсэн	100%	100%
ЕХОБ-ны санхүүжилт					
3	TFP	Толгойт дэд төвийн үерийн хамгаалалтын барилга байгууламж	1.8 км үерийн хамгаалалтын суваг Е-1 үерийн хамгаалалтын суваг трасст дулааны шугам өртөж, нэмэлт ажлын зураг, төсвийг боловсруулж, батлуулсан. 2025 онд ТЭЦ-4 -н засвар, үйлчилгээний хуваарьт оруулж, гүйцэтгэхээр хүлээгдэж байна.	90.45%	90.45%
4	TFP-A	Толгойт дэд төвийн үерийн хамгаалалтын барилга байгууламж	5.2 км үерийн хамгаалалтын суваг	15.77%	15.77%
5	SHTSC	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй сургууль цэцэрлэгүүдийн дэд бүтцийг бие даасан дэвшилтэт технологиор шийдвэрлэх ажил	Хийн халаалтын зуух суурилуулах ажил - 9ш сургууль Нөөц цахилгаан үүсгэвэр суурилуулах ажил - 4 сургууль Ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах ажил - 5ш сургууль Бохир усны саармагжуулах төхөөрөмж суурилуулах ажил - 1ш сургууль	90.00%	1. СХД, Баянхошуунд баригдаж байгаа шинэ сургууль нь ашиглалтад ороогүй байгаа. 2. 71-р сургуулийн гадна цахилгааны дэд өртөө барих ажил нь хийгдсэн боловч НХОГ-аас өөрчлүүлэх хүсэлт ирсэн

№	Багцын дугаар	Ажлын нэр	Ажлын тоо хэмжээ	Ажлын явц	
				2023. 12.30	2024. 12.30
6	SHTSC-B	Сонгинохайрхан дүүргийн 23 дугаар хороо ГХДТ-2019-1 багцын орон сууцны “Оргил” төслийн гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил	Ариутгах татуургын шугам - 3км Гадна цэвэр усны шугам - 1,6км Дулаан хангамжийн шугам - 2км УДДТ-2ш	2.92%	33.26%
7	TRDH11-C	Толгойт дэд төвийн ус хангамжийн ажил	2.8 км ус хангамжийн шугам сүлжээ 1 насос станц	19.65%	85.03%
8	SHTSC-C	Сэлбэ дэд төвийн бохирын гол коллекторын шугам хоолойн шинэчлэл, засварын угсралтын ажил	БУХ59-БУХ66 худгийн хооронд 462.4м шугамыг зөөж, шилжүүлэх 33ш худаг засварлах	0%	80.60%
				/Улаанбаатар хотын тогтвортой автозам, тээвэр төслийн Сэлбэ гол дагуу төлөвлөж буй автозамаас шалтгаалж, трасст өөрчлөлт орсноор ажил удааширсан/	

Хүснэгт 19 Барилгын ажлын явц

БҮРЭЛДЭХҮҮН 2. НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 4 барилгын ажил үргэлжлэн хийгдэж байна.

№	Багцын дугаар	Ажлын нэр	Ажлын тоо хэмжээ	Ажлын явц	
				2023. 12.30	2024. 12.30
АХБ-ны санхүүжилт					
1	TBC	Толгойт дэд төвд сургалтын төв барилгын угсралтын ажил	2023.46м ² талбайтай 2 давхар үйлдвэрлэл, үйлчилгээний барилга Авто машины зогсоол 20ш Явган хүний зам, талбай Дугуйн зогсоол	72.25%	81.90%
ЕХОБ-ны санхүүжилт					
2	FSBKH	Нэгдүгээр зэрэглэлийн аврах, гал түймэр унтраах 29 дүгээр ангийн барилга	Нийт 3 блокоос бүрдсэн 4 давхар барилга, гадна тохижилт, авто зогсоол, гадна гэрэлтүүлэг, гадна шугам сүлжээ, цахилгааны дэд өртөөний барилга А блок - 576м ² талбайтай Б блок - 720м ² талбайтай В блок 288м ² талбайтай	26.50%	59.15%
				Барилгын төмөр бетон цутгалтын ажил дууссан. Дотор, гадна өрлөгийн ажил хийгдсэн.	

№	Багцын дугаар	Ажлын нэр	Ажлын тоо хэмжээ	Ажлын явц	
				2023. 12.30	2024. 12.30
3	SFS	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалах байр	2612.3м² талбайтай 2 давхар барилга; гадна инженерийн шугам сүлжээ, дагалдах тоног төхөөрөмж, явган зам талбай, талбайн тохижилт, ногоон байгууламж, халаалттай дэд өртөөний барилга дагалдах цахилгааны тоног төхөөрөмж	46.00%	83.65%
4	TSC	Ерөнхий болосвролын 42 дугаар сургуулийн барилга угсралтын ажил	А, Б, В блок барилга: Тэнхлэгээрээ 58.0*51.8м хэмжээтэй, Н хэлбэртэй 3 давхар, зоорийн давхартай Барилгын ажлын нийт талбай: 2651.17м²	0%	36.32%

Хүснэгт 20 Барилгын ажлын явц

Дээрх 2 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд гүйцэтгэгдэж байгаа барилгын ажлын зургийг Хавсралт 7-д хүргүүлэв.

Тайлант хугацаанд SHTSC "Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй сургууль цэцэрлэгүүдийн дэд бүтцийг бие даасан дэвшилтэт технологиор шийдвэрлэх ажил" гэрээнд техникийн комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах мөн улсын комисст хүлээлгэж өгөх холбоотойгоор гэрээний хугацааг 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдөр хүртэл гэрээний хугацааг сунгасан. .

БҮРЭЛДЭХҮҮН 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ

Энэ бүрэлдэхүүн хэсгийн зорилго нь төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж барилгын ажлуудтай холбоотой болон хот төлөвлөлт, дэд төвүүдийн хөгжлийг боловсронгуй болгох, дэд төвийн бүтээн байгуулалтын талаарх иргэдийн ойлголтыг төлөвшүүлэх, тэдний оролцоог хангах, дэд бүтцийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаа, менежментийг сайжруулах замаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавхыг дээшлүүлэх юм.

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна

9.1.2.4. АХБ-НЫ ХАМГААЛЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц

Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн санхүүжилтийг АХБ-ны зээлийн хөрөнгөөс санхүүжүүлж байгаа ба НЗД-ын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/300 дугаар захирамжийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлж байгаа ба төсөл хөтөлбөр 2 дугаар үе шат Дамбадаржаа дэд төв төсөл хөтөлбөр 3 дугаар үе шат Толгойт дэд төв болон НЗДТГ-аас нэмэлтээр хэрэгжүүлж байгаа бусад нэмэлт ажлын газар чөлөөлөлтийн ажлыг гүйцэтгээд байна.

Төслийн III үе шатны газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн нийт 4 төлөвлөгөө, 4 зохистой байдлын тайлан боловсруулж АХБ-аар батлуулаад байна. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө болон зохистой байдлын тайланг боловсруулахад тухайн сонгосон байршил болон амьдарч буй иргэдтэй зөвлөлдөх уулзалтууд хийх болон нөлөөлөлд өртөх магадлалтай иргэдээс нийгэм эдийн засгийн судалгаа авч 2024 оны 12

сарын байдлаар газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн нийт ажлын явц 95,2%-д хүрсэн байна.

Төслийн III үе шатны газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртсөн нийт 530 иргэн хуулийн этгээдээс 501 иргэн хуулийн этгээдийн 34,426,780,581 төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

№	Санхүүжүүлэгч	Нөхөн олговрын дүн
1	НЗДТГ-ын төсөв	139,600,300.00
2	АХБ-ны зээл	34,287,180,281.00
	Нийт	34,426,780,581.00

Хүснэгт 21. Нөхөн олговор

Эндээс:

Хүлээгдсэн 9 буюу бичиг баримтын зөрчилтэй айл өрхүүд мөн 22 иргэн, хуулийн этгээдтэй ажлын явцад зөвшилцөнө.

Толгойт болон Баянхошуу дэд төвийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд нөлөөлөлд өртсөн нийт 501 иргэн, хуулийн этгээд нөхөн олговроо авсан ба үүнээс газар өмчлөгч, эзэмшигч эрхтэй 342 иргэн, хуулийн этгээдээс нөлөөлөлд бүтэн өртсөн 303 иргэнээс 303 иргэний гэрчилгээг хүчингүй болгуулахаар холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгч ҮХХ-ийн хувийн хэргийг хаалгасан. Хэсэгчлэн өртсөн 39 өрхийн газрын гэрчилгээ болон кадастрын зурагт өөрчлөлт оруулахаар холбогдох материалуудыг бэлтгэн НГЗБА, ДУБХ-т хүлээлгэн өгч, хамтран ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд 33 иргэн хуулийн этгээдийн газрын гэрчилгээ болон кадастрын зургийг өөрчлөн хүлээлгэн өгсөн байна.

Шархад дэд төвийн газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц

Төсөл хөтөлбөрийн 3 дугаар үе шат Шархад дэд төвийн хүрээнд авто зам, инженерийн шугам сүлжээ, үерийн далангийн зураг төслийн ажил бүрэн дууссан ба НЗД-ийн А/1415 тоот захирамжаар БЗД-ийн 24-р хорооны нутаг дэвсгэрт Усан сангийн зориулалтаар 5007м² газрыг НЗДТГ-ын нэр дээр газар эзэмших гэрчилгээг гаргуулаад байна.

Ажлын нэр	ГЧ Төлөвлөсөн					ГЧ-ийн гүйцэтгэл 2024 оны 12 сарын байдлаар					Санхүүжилт авсан иргэн, хуулийн этгээд
	Бүтэн	Хагас	Хажуу өрх	Нийт НӨ нэгж талбар	НӨ иргэн, хуулийн этгээд	Бүтэн	Хагас	Хажуу өрх	Нийт НӨ нэгж талбар	НӨ иргэн, хуулийн этгээд	
А. Толгойт дэд төв											
Сургалтын төв болон ногоон байгууламж /цэцэрлэгт хүрээлэнгийн ажил	0	1	0	1	1	0	1	0	1	1	1/1
Үерийн далан	28	9	16	37	53	28	9	16	37	53	50/50
Автозам инженерийн шугам сүлжээ болон техникийн барилга байгууламж, эрүүл мэндийн төвийн ажил	256	127	116	383	499	256	64	126	320	446	420/420
Бага сургуулийн барилгын ажил	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Нийт (А)	284	137	132	421	553	284	74	142	358	500	471/471
Б. Шархад дэд төв											
Үерийн далан	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Нийт (Б)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
В. Бусад дэд төвүүд											
Баянхошуу дэд төвийн тохижилтийн ажил	2	0	0	2	2	2	0	0	2	2	2/2
Баянхошуу дэд төвийн сургуулийн саарал усны ажил	2	0	0	2	2	2	0	0	2	2	2/2
Гал унтраах 29-р анги болон спортын нэмэлт орц гарцны автозамын ажил	0	0	0	0	0	15	2	9	17	26	26/26
Нийт (В)	4	0	0	4	4	19	2	9	21	30	30/30
Нийт дүн	288	137	132	425	557	303	76	151	379	530	501/501

Хүснэгт 22 Төслийн 3 үе шатны газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн мэдээлэл

Газрын эрхгүй иргэдийг Түрээслээд өмчлөх орон сууцанд хамруулах ажлын явц

Азийн хөгжлийн банкны “Хамгааллын бодлогын баримт бичиг”, 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн “Азийн хөгжлийн банкны Хөндлөнгийн хариуцлагын газарт гаргасан гомдлыг барагдуулах Ерөнхий санамж бичиг”-ийн 10.4, Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн Бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогчийн 2019 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн газар чөлөөлөлтөд өртсөн газрын гэрчилгээгүй өрхүүдэд газар олгох эсвэл зорилтот бүлгийн орон сууцаар хангах ажлыг зохион байгуулах удирдамж”-ийн дагуу дэд төвүүдийн газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртсөн газрын эрхгүй иргэдийг АХБ-ны санхүүжилтээр СХД-ийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй түрээсийн 126 айлын орон сууцанд хамрагдах 123 иргэний хүсэлтийг бүртгээд байна.

Түрээсийн 126 айлын орон сууцыг байнгын ашиглалтад хүлээн авах Улсын комисс 2023 оны 6 дугаар сард ажиллаж хүлээн авсан. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн багаас ТӨОС-нд иргэдийг хамруулах асуудлаар НОСК-ийн холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж зөвлөлдсөн ба цаашид ажлын хэсэг байгуулах, НИТХ-ын тогтоол болон НЗД-ын захирамжаар баталгаажуулан ажиллахаар төлөвлөсөн. 2024 оны НИТХ-ийн 29 дүгээр тогтоолоор 126 айлын орон сууцыг Нийслэлийн өмчид бүртгэн авсан ба НОСК цаашид ашиглалтыг хариуцан ажиллах тул ТХН-ээс дээрх 123 өрхийг ТӨОС-нд хамруулах шаардлагатай байгаа тухай НОСК-д 2024.02.27-ны №205, НЗДТГ-т 2024.03.20-ны №268 тоот албан бичиг хүргүүлсэн ба ТХН-ээс 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн ТӨОС-нд хамрагдах иргэдтэй уулзалт зохион байгуулан иргэдийн өр орлогын харьцааны судалгааг гаргаж дууссан байна. Судалгаанд хамрагдах нийт 123 иргэнээс өр орлогын харьцааны шаардлага хангасан 72, шаардлага хангаагүй 11, ТӨОС-нд хамрагдахаас татгалзсан 28, холбоо тогтоож чадаагүй 12 иргэн байна. Эдгээр иргэдийг ТӨОС-нд хамруулах тухай асуудлыг 2024 оны 11 дүгээр сарын 6-ны НЗД-ын зөвлөлийн хурлаар оруулж дэмжигдсэн бөгөөд 75 өрхийг ТӨОС-нд хамруулах ажлыг НОСК-зохион байгуулахаар ажлын төлөвлөгөө, хуваарилалтыг боловсруулан ажиллаж байгаа бөгөөд одоогоор 36 иргэний байрны сонголтыг хийлнүүлсэн бөгөөд материалаа бүрдүүлсэн 29 иргэнтэй гэрээ байгуулсан байна.

Дэд төвүүд	Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй	Өөрсдөө татгалзсан	5-10 удаа залгасан ирээгүй
Баянхошуу	9	0	2	3
Сэлбэ	16	1	2	2
Дамбадаржаа	22	7	9	4
Баянхошуу г/у	0	0	2	0
Толгойт	25	3	13	3
нийт	72	11	28	12

Хүснэгт 23 Түрээсийн орон сууцад хамаарах иргэдийн мэдээлэл

Нийгэм болон жендер, Олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаа

2024 оны 4 дүгээр улирлын байдлаар төслийн III үе шат, Нийгмийн хамгаалал, жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөний нийт хэрэгжилт 49.8% гүйцэтгэлтэй байна.

Төслийн III үе шат, Толгойт дэд төвд дараах үйл ажиллагаануудыг зохион байгууллаа. Үүнд:

Тайлангийн хугацаанд Нийгэм жендерийн төлөвлөгөөний хүрээнд Толгойт дэд төвийн иргэд, хороодын албан хаагчдад төслийн явцын мэдээлэл өгөх 4 удаагийн уулзалтыг 192 (121 буюу 63% эмэгтэй) оролцогчтойгоор зохион байгууллаа. Мөн дэд төвийн иргэд,

хорооны албан хаагчид, хүүхэд залууст чиглэсэн 5 төрлийн 31 удаагийн чадавхжуулах сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж 2092 оролцогчдыг хамруулжээ. Эдгээр оролцогчдын 1158 буюу 55.4% нь эмэгтэй байна.

- Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалт

Толгойт дэд төвийн зорилтод хороодын хүүхэд, гэр бүлийг хүчирхийлэл, дарамтаас хамгаалах чиг үүрэг бүхий хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах зорилгоор 2024 оны 1 сард 3 өдрийн “Кейс менежмент” сургалтыг зохион байгууллаа. Сургалтыг СХД-ийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, “Галт шувуу” НҮТББ-тай хамтран зохион байгуулсан ба нийт 103 албан хаагч хамрагдсанаас 80 эмэгтэй оролцогч байв.

Оролцсон хамтарсан багийн гишүүд хүүхэд, гэр бүлд хамгааллын үйлчилгээг үзүүлэх ялангуяа жендерт суурилсан хүчирхийллийн хохирогчидтой ажиллах кейс менежментийн арга зүй, Кейс менежментийн үйлчилгээний үе шатын дагуу хохирогчдод хамгааллын үйлчилгээг үзүүлэх, нотлох баримтыг хэрхэн бүрдүүлэх тухай анхан шатны ойлголт мэдлэгтэй болж, Сонгинохайрхан дүүргийн түвшинд түгээмэл гарч буй асуудал болох үе тэнгийнхний дарамт, хүчирхийлэл, охид эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэрэгтэй хэрхэн ажиллах тухай арга барилд суралцаж, өөрсдийн стратегийг боловсруулсан. Мөн бүх суралцагсад 1 жишээ кейс дээр нөлөөллийн үнэлгээ хийж, холбон зуучлах үйл ажиллагааг төлөвлөн, хамтарсан багийн үнэлгээний картыг бүрэн бөглөж, сургалтыг илүү практик байдлаар хийсэн нь сургалтын үр дүнтэй болголоо.



Зураг 14 Хамтарсан багийн сургалтын явц

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, охид, эмэгтэйчүүдийн аюулгүй байдлыг хамгаалах нөлөөллийн ажлын төслийг зорилтот хороодын “Хамтарсан баг”-тай хамтран хэрэгжүүлэв.

Толгойт дэд төвийн зорилтод хороодын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах зорилгоор 2024 оны 1 сард 3 өдрийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтын үеэр УБХГХХХОДХ төсөл, хамтарсан баг хамтран нөлөөллийн бичил төслийг санаачлан хэрэгжүүлэхээр болсон. Үүний хүрээнд төслийн зүгээс зорилтот хороодын хамтарсан баг, Засаг даргын ажлын албанд “Охид, эмэгтэйчүүдийг жендерт суурилсан хүчирхийллээс хамгаалах” үйл ажиллагааны удирдамжийг илгээсэн. Уг удирдамжийн дагуу саналаа ирүүлсэн 2-р хорооны хамтарсан багийн “Хүндэлье, хайрлая” төсөл, 35-р хорооны “Тэгш харилцаа” төслийн саналууд дэмжигдэн хэрэгжлээ.

Төслөөр "Хүндлэл ба хайр" сэдэвт самбар бүтээх зорилготой хүүхдийн бүтээлийн уралдаан зарлагдаж, тус самбарыг Толгойт дэд төвийн хамгийн том таван хүнсний дэлгүүрт байршуулсан бол Өсвөр насны дээрэлхэлтийн эсрэг “Өсвөр насныхны дунд дээрэлхэх явдал газар авах ёсгүй” сэдэвт аян өрнөсөн. Мөн эерэг, хүмүүжлийн орчныг бүрдүүлэх зорилгоор 42 ба 107-р сургуулийн эцэг эхчүүдэд "Эерэг хүмүүжлийн арга" сэдэвт сургалтыг зохион байгуулж, 35-р хорооны залуу ээжүүдэд зориулан “Сэтгэл зүйгээ хэрхэн удирдах, хүүхдийн хүмүүжлийн эерэг арга болон эрүүл мэндийн боловсрол олгох” сургалтууд зохион байгуулагдлаа. Сургалт, нөлөөллийн ажлын үеэр хамтарсан баг нь өөрсдийн үйл

ажиллагааг танилцуулж, яаралтай үед хэрхэн үйлчилгээ авах, хаана хандах зэрэг мэдээллийг өгч байв.

Эдгээр төсөлд нийт 305 насанд хүрэгчид, үүнээс эмэгтэй 109 иргэд, нийт 892 хүүхэд, үүнээс 537 охид хамрагдлаа.



Зураг 15 Нөлөөллийн ажлын төслийн явц



Олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаа

Төслийн олон оролцооны үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд иргэдийн бүлэг, оршин суугчдын зөвлөл, дэд төв хөгжүүлэх зөвлөлийг байгуулах ажлаар 1-р улиралд нийт 8 удаагийн уулзалтыг Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 20, 22, 34, 35-р хорооны Засаг дарга болон хэсгийн ахлагч нартай хийлээ. Нийт 56 албан хаагчид хамрагдлаа. Тухайн уулзалтуудаар иргэдийн бүлэг, олон нийтийн оролцоо түүний ач холбогдлын талаар танилцуулга хийж төслийн хил доторх хорооны хэсгүүдийн хил хязгаарыг хэсгийн ахлагч нартай хамтран газрын зурагт буулган, бүлэг байгуулах ажлын бэлтгэлийг хангалаа.

- Толгойт дэд төвийн иргэд, хороодын албан хаагчдад төслийн явцын мэдээлэл өгөх уулзалтуудыг зохион байгууллаа.

Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн III үе шат болох Толгойт дэд төвийн иргэд, хороодын албан хаагчдад төслийн явцын мэдээ хүргэх 4 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг 2024 оны 5 болон 12 дугаар саруудад зохион байгууллаа. Уулзалтаар төслийн явц, барилга угсралтын ажлуудын танилцуулга, ХАБЭА зааварчилгаа, аюулгүй байдлын зөвлөмж, төслийн нийгэм жендерийн төлөвлөгөөний хүрээнд хэрэгжиж буй ажлууд, санал гомдлын механизм болон олон нийтийн оролцоотой хяналт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх зөвлөмж зэрэг олон талын мэдээллийг өгч, санал солилцов. Эдгээр уулзалтуудад нийт 192 (121 буюу 63% эмэгтэй) оролцогч хамрагдлаа. Энэхүү үйл ажиллагаа нь иргэдийн мэдээлэл авах, оролцоог нэмэгдүүлэх, аюулгүй байдлыг хангах, төслийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэн ажилласан.

- Толгойт дэд төвийн иргэд, хүүхэд залууст “Эрүүл мэндийн цогц боловсрол” олгох сургалт зохион байгуулав.

2024 оны 11-р сард “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн нийгэм жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд Толгойт дэд төвийн иргэд, хүүхэд залууст эрүүл мэндийн боловсрол олгох 4 удаагийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтыг Сонгинохайрхан дүүргийн Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэс, Залуучуудын хөгжлийн төв, “Хамтдаа” ТББ-тай хамтран зохион байгууллаа. Сургалтад нийт 300 оролцогч, үүнээс 148 эмэгтэй оролцлоо. Сургалтаар бэлгийн цогц боловсрол, БЗДХ, ХДХВ/ДОХ, гэр бүл төлөвлөлт, сэтгэл зүйн эрүүл мэндийн талаар мэдээлэл өгч, оролцогчид практик кейсүүдээс суралцсан. Энэ удаагийн сургалт нь залуу албан хаагчид болон цэргийн албанд шинээр элсэн орсон залууст чиглэсэн, эрэгтэйчүүдийн сэтгэцийн эрүүл мэндийг хөндсөн онцлогтой байлаа.



Зураг 16 Олон нийтийн уулзалтуудын явц

- Толгойт дэд төвийн хүүхэд залууст хорт зуршлаас сэргийлэх сургалт зохион байгуулав.

Төслийн нийгэм жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан чадавхжуулах сургалтын хүрээнд Толгойт дэд төвийн хүүхэд залууст хорт зуршлын талаар болон түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг таниулах зорилгоор “Өдөөгчөө ол” сургалтыг 2024 оны 11 сард зохион байгууллаа. Сургалтыг СХД-ийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэс, тус дүүргийн Залуучуудын хөгжлийн хэлтэс, “Зөв Дадал” ТББ-тай хамтран зохион байгуулав. Нийт 5 удаагийн сургалтанд 198 хүн хамрагдсанаас 135 эмэгтэй байв. Сургалтаар хорт зуршлын үндэс, ирээдүйн хор уршиг, зуршил хэрхэн үүсдэг талаар тайлбарлаж, анхны тайтгарал нь хорт зуршлын суурь болдгийг онцоллоо. Оролцогчидтой хэрхэн зөв тайвшрах, сөрөг мэдрэмжийг зөв зохицуулах талаар ярилцаж, найз нөхөд, ойр дотнын хүмүүсийн зан ааш, ганцаардал, зуршилд өдөөгч дохио болох эсэхийг бодолцон, урьдчилан сэргийлэх зөвлөмж өглөө. Мөн мэдлэг нь сэрэмжлэх дохио болдог тул үргэлж анхааралтай байхыг уриалав.

- Зорилтот хороодын иргэд, хүүхдүүдэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалт зохион байгуулав.

Толгойт дэд төвийн ерөнхий боловсролын 42, 107-р сургууль, 81, 111-р цэцэрлэгийн хүүхдүүдэд замын хөдөлгөөний аюулгүй байдал болон барилгын орчинд аюулгүй зорчих талаар мэдлэг олгох сургалт зохион байгууллаа. Сургалтад нийт 272 хүүхэд хамрагдсанаас 134 нь охид байв.

Мөн 81-р цэцэрлэгийн эцэг эх, асран хамгаалагчдад бага насны хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх болон барилга угсралтын үеэр анхаарах асуудлуудын талаар сургалтыг зохион байгуулав. Сургалтад 22 эцэг эх, асран хамгаалагчид хамрагдсанаас 15 нь эмэгтэйчүүд байв.



Зураг 17 Сургалтын явцаас

- Жижиг, дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих үйл ажиллагаа

Жижиг, дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд Толгойт дэд төв, Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 20, 34, 35-р хорооны иргэдэд зориулж доорх 2 удаагийн өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулав.

- Сонгинохайрхан дүүргийн бизнес эрхлэгчдийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Бизнес эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн өдөрлөгийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ЖДҮ газар, болон Нийслэлийн хөдөлмөр, халамжийн газартай хамтран 2024 оны 1-р сард Сонгинохайрхан дүүргийн 1-р хорооны Иргэний танхимд зохион байгуулав. Өдөрлөгийн үеэр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ЖДҮ газрын Зээл, төслийн хэлтсийн мэргэжилтэн, болон Нийслэлийн хөдөлмөр, халамжийн газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд иргэдэд хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрийн мэдээ мэдээлэл, зөвлөгөөг өгч, асуултад хариулан ажиллав.



Зураг 18 Зээлийн өдөрлөгийн явц

- Толгойт дэд төвийн бизнес эрхлэгчдийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Бизнес эрхлэгчдийг дэмжих банкны өдөрлөгийг Хаан банк, Голомт банк, Төрийн банкнуудтай хамтран 2024 оны 1-р сард Сонгинохайрхан дүүргийн 1-р хорооны Иргэний танхимд зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр зээлийн мэдээлэл, зээлийн бүтээгдэхүүнүүд, зээлийн материал бүрдүүлэлтэд тавигдах шаардлага, анхаарах зүйлс болон зөвлөгөөг банкнууд иргэдэд өгч асуултад хариулан ажиллаа.



Зураг 19 Банкны өдөрлөгийн явц

9.1.2.4. САНХҮҮЖИЛТ

Эх үүсвэр	Санхүүжилт	Эзлэх хувь	Зарцуулалт	%
<i>АХБ-ны санхүүжилт</i>				
<i>COL зээл</i>	18.6	24.00%	10.16	54.62%
<i>OCR зээл</i>	25.05	32.32%	6.71	26.79%
<i>Дэд дүн</i>	43.65	56.32%	16.87	38.65%
<i>НЗДТГ-ын төсөв</i>	15.21	19.62%	0.57	3.75%
<i>ЕХОБ-ны санхүүжилт</i>	18.65	24.06%	8.72	46.76%
<i>Нийт</i>	77.51	100.00%	26.16	33.75%

Хүснэгт 24 Санхүүжилтийн зарцуулалт

10. Цаашид хийхээр төлөвлөсөн ажлууд:

Хөтөлбөрийн хэрэгтэд хангалттай төсвийг тодотголд тусгах

11. Тулгамдаж буй асуудлууд:

Төслийн хэрэгжилтийг удаашруулж буй дараах асуудлууд байна. Үүнд:

- Дэнжийн мянга дулааны станц барих ажлыг төсөвт суулгах

Оргил ачааллын горимд ажиллах 93МВт хүчин чадалтай Дэнжийн мянга дэд төвд баригдах дулааны станц барихад шаардлагатай газар чөлөөлөлтийн 10.36 тэрбум төгрөг, барилгын ажлын 61.0 тэрбум төгрөг нийт 71.36 тэрбум төгрөгийг улс, нийслэлийн төсөвт тусгах шаардлагатай

- Зээлийн хөрөнгөөр бий болсон барилга байгууламжийн ашиглагч байгууллагыг урьдчилан тодорхойлох

Төслийн хүрээнд зээлийн хөрөнгөөр баригдаж, байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажилласан инженерийн барилга, байгууламжуудыг баригдаж дуусахаас өмнө ашиглагч байгууллагыг урьдчилан тодорхойлж, өмчид хүлээлгэж өгөх процессыг

хурдасгах шаардлагатай. Зарим байнгын ашиглалтад оруулсан барилгуудыг ашиглагч байгууллага болох УБДС ТӨХК, УБЦТС ТӨХК, МХС ТӨХХК нар зээлийн эргэн төлөлтийг хэн төлөх, зээлтэй барилга байгууламжийг ашиглагч байгууллагад балансаас балансад хүлээлгэж өгөөгүйгээс хөрөнгө эзгүйдэх, төлөвлөгдөөгүй ашиглалтын зардал ТХН дээр гарч байна.

12. Шийдвэрлэх арга зам, авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

13. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл:

а. Төслийн захирлын нэр: Нийслэлийн Орон сууц бодлогын газрын дарга Г.Ганхүү

б. Төслийн зохицуулагчийн нэр: Д.Авирмэд

в. Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Бага тойруу 1, Амарын гудамж 2, Соёлын төв өргөө, Г корпус #415

г. Холбоо барих утас: + (976)-7000-3099

д. Цахим шуудангийн хаяг: info@ub-subcenter.mn

13.1. ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Хөтөлбөрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах үүднээс дэд төвүүдийн иргэдэд төслийн үйл ажиллагааг танилцуулах, явцын мэдээлэл өгөх зэргээр олон удаагийн зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулж улирал тутмын сониныг тараан ажилласан.

Төслийн үйл ажиллагааны тайланг улирал бүрээр, барилгын ажлын явцын мэдээллийг сар бүр бэлтгэн төслийн оролцогч талуудад цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүргэж ажиллаж байна.

Хөтөлбөрийн цахим хуудсанд www.ub-subcenter.mn байрлах мэдээллийг дараах байдлаар төрөлжүүлсэн.

1. Үйл ажиллагааны ил тод байдал

Хөтөлбөрийн үйл ажиллагааны явцын тайлан мэдээг байршуулдаг.

2. Хүний нөөцийн ил тод байдал

Төслийн нэгжийн хүний нөөцийн холбогдолтой мэдээллүүд буюу нээлттэй ажлын байрны зарууд, анкетын загвар, байгууллагын дотоод журам, ёс зүйн дүрэм, ажилд сонгон шалгаруулах журам зэрэг мэдээллийг байршуулдаг.

3. Албан хаагчдын утасны жагсаалт

Төслийн нэгжийн ажилчдын холбоо барих мэдээлэл, өргөдөл гомдол хариуцсан албан хаагчийн холбоо барих мэдээлэл зэргийг байршуулсан.

4. Шилэн данс

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011), Шилэн дансны тухай хууль (2014)-ийн дагуу төслийн худалдан авах ажиллагааны болон санхүүгийн мэдээллийг шилэн дансны цахим хуудас www.shilendans.gov.mn холбогдох мэргэжилтнүүд тодорхой хугацаанд нь байршуулж ажиллаж байна.

Хөтөлбөрийн цахим хуудсыг ажлуулж мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байгаа бөгөөд нийгмийн сүлжээгээр төслийн үйл ажиллагааны явц, онцлох мэдээ мэдээллийг цаг алдалгүй нийтэлж ажиллаж байна. (FB page: Гэр Хорооллыг Хөгжүүлэх Хөрөнгө Оруулалтыг Дэмжих Хөтөлбөр Төсөл)

13.2. ӨРГӨДӨЛ ГОМДЛЫГ ХҮЛЭЭЖ АВАХ ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь гомдол барагдуулах механизмыг хэрэгжүүлэхдээ Нийслэлийн Засаг Даргын 2022 оны А/1049-р захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ыг мөрдөж ажиллаж байна.

Төслийн хүрээнд 2024 оны 1-р сарын 1-ний өдрөөс 12-р сарын 31-ний өдрийн хооронд нийт 21 өргөдлийг оршин суугчдаас ирүүлсэн байна. Үүнээс 11 өргөдлийг төсөл хэрэгжүүлэх нэгжид, 5 өргөдлийг Засгийн газрын 11-11 төвд, 2 өргөдлийг Дижитал сити аппликейшнээр, 2 өргөдлийг Нийслэлийн лавлагаа мэдээллийн төвийн 1800-1200 дугаарын оператораар, 1 өргөдлийг хороонд ирүүлсэн бөгөөд төлөв байдлыг нь судалж үзвэл:

№	Өргөдлийн төрөл	Ирсэн өргөдлийн тоо
1	Нөхөх олговортой холбоотой өргөдөл	7
2	Нөхөн сэргээлтийн тухай өргөдөл	3
3	Инженерийн байгууламжтай холбоотой өргөдөл	11
Нийт		21

Хүснэгт 25 Өргөдөл гомдол

Нийт ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг судалж үзвэл 14 өргөдлийг иргэний талд шийдвэрлэлээ. Харин өргөдөл шийдвэрлэлтийн хугацааг судалж үзвэл 3 өргөдлийг 5 хоногт, 3 өргөдлийг 15 хоногт, 13 өргөдлийг 30 хоногт, 1 өргөдлийн хугацааг 30 хонгоор сунгуулсан байна. Төсөлтэй холбоотойгоор ирсэн нийт өргөдөл гомдлыг 100% хугацаандаа шийдвэрлэж байгаа бөгөөд хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл гомдол, санал байхгүй байна.

13.3. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ДАГАЖ МӨРДӨЖ БУЙ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

Төслийн үйл ажиллагаанд баримтлах үндсэн баримт бичгүүдэд дараах баримт бичгүүд багтана. Үүнд:

1. Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр (СЕХ) /2014 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Монгол УИХ-аар соёрхон баталсан/
2. СЕХ-ийн дагалдах баримт бичгүүд:
 - a. Үе шат 1-ийн санхүүжилтэд хамаарах МУ-ын Засгийн Газар ба АХБ хооронд байгуулсан зээлийн гэрээ:
 - i. Төслийн гэрээ МОН-3098, МОН-3099, МОН-0380 /2013 оны 6 дугаар сарын 30/
 - ii. Тусгай сангийн зээлийн гэрээ МОН-3099 /2013 оны 6 дугаар сарын 30/
 - iii. Ердийн эх үүсвэртэй санхүүжилтийн зээлийн гэрээ МОН-3098 /2013 оны 6 дугаар сарын 30/
 - iv. Буцалтгүй тусламжийн санхүүжилтийн гэрээ МОН-0380 /2013 оны 6 дугаар сарын 30/
 - b. Үе шат 2-ын санхүүжилтэд хамаарах МУ-ын Засгийн Газар ба АХБ хооронд байгуулсан зээлийн гэрээ:
 - i. Төслийн гэрээ МОН-3525, МОН-3526(COL) /2017 оны 12 дугаар сарын 06/
 - ii. Концессын ердийн эх үүсвэртэй санхүүжилтийн зээлийн гэрээ МОН-3526(COL) /2017 оны 12 дугаар сарын 06/



Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

- iii. Ердийн эх үүсвэртэй санхүүжилтийн зээлийн гэрээ МОН-3525/2017 оны 12 дугаар сарын 06/
- c. Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн дагуу МУ ба Европын Хөрөнгө Оруулалтын Банктай байгуулсан зээлийн гэрээ FI83.097, FI83.873 /2013 оны 6 дугаар сарын 30, Төслийн үе шат 1,2-т хамаарна/
- d. Олон шатлалт санхүүжилтийн зээлийн шугам (ОШСЗШ)-ын удирдлагын баримт бичиг /АХБ-ны Удирдах Зөвлөлөөс 2013 оны 08 дугаар сард баталсан, Төсөл 2-т холбогдуулан 2017 оны 3 дугаар сард шинэчлэн баталсан/
3. МУ-ын Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохих байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”

Тайлан хянасан:


Д.Авирмэд, Төслийн зохицуулагч

Тайлан боловсруулсан:

С.Гэрэлмаа, ХШҮ-ны мэргэжилтэн



БАЯНХОШУУ ДЭД ТӨВИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ



1. 20 АЙЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ОРОН СУУЦ
2. 240 ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ
3. БИЗНЕС ИНКУБАТОР
4. 35/10кВ ДЭД СТАНЦ (32МВ)
5. ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН, 2.4 ГА
6. 650 СУУДАЛТАЙ
СПОРТ ЦОГЦОЛВОР
7. ГЭЛ УНТРААХ, АБРАХ АНГИ
8. 240 ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ
9. ҮЕРИЙН
ХАМГААЛАЛТЫН
ДАЛАН
10. ОЛОН НИЙТИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ
11. ТОХИЖИЛТЫН
АЖЛУУД
12. 50 АЙЛЫН
ОРОН СУУЦ
13. УРБАН ПЛАЗА
13 ГА

СЭЛБЭ ДЭД ТӨВИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ



БИЗНЕС ИНКУБАТОР



240 ХҮҮДИЙН ЦЭЦЭРЛЭГ



МЭДЭЭЛЭЛ ХӨЛӨСӨНҮ БАРИЛГА



50 АЙЛЫН ОРОН СУУЦ



ЗВМБТ
'СЭЛБЭ' ДУГААНЫ СТАНЦ



1000М²
УСАН САН, НАСОС СТАНЦ



ҮЕРИЙН
ХАМГААЛАЛТЫН
ДАПАН ДАГУУ
ТОХИЖИЛТ



ҮЕРИЙН
ХАМГААЛАЛТЫН
ДАПАН ДАГУУ
ТОХИЖИЛТ

УС ХАНГАМЖИЙН СИСТЕМИЙН НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ

УС ХАНГАМЖ

- Улаанбаатар хотын ус хангамжийн найдвартай ажиллагааг дээшлүүлсэн;
- Ус хангамжийн станцуудын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагын системд шилжүүлсэн;
- Жилд 200 сая төгрөгийн эрчим хүчний хэмнэлтийг бий болгосон;

АРИУТГАХ ТАТУУРГА

- Резервуарын ашиглалтын хугацааг 30 жилээр сунгасан;
- Аэротанкийн ашиглалтын хугацааг 30 жилээр сунгасан;
- Агааржуулалтын системийг сайжруулсан бактерийн төрөл, тоо нэмэгдэж, биологийн цэвэрлэгээний чанар сайжирсан;

МАГИСТРАЛЬ ШУГАМЫН АЖИЛ

ЦЭВЭР УСНЫ ШУГАМ (900мм)	4.01 км
ЦЭВЭР УСНЫ ШУГАМ (600мм)	8.07 км
АРИУТГАХ ТАТУУРГЫН ШУГАМ (600мм)	1.70 км

ШИЛЭН КАБЕЛЬ ХОЛБОЛТЫН АЖИЛ

НИЙТ ШИЛЭН КАБЕЛЬ	43 км
- ҮЙЛДВЭРИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН 16 ХУДАГ	7 км
- МАХ-ЫН ЭХ ҮҮСВЭРИЙН 11 ХУДАГ	3.6 км
- ГАНУУРТ ЭХ ҮҮСВЭРИЙН 21 ХУДАГ	19.3 км
- ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН ОБЪЕКТУУД	13.1 км

СКАДА НЭГДСЭН ХЯНАЛТ УДИРДЛАГЫН СИСТЕМ

- НЭГДСЭН УДИРДЛАГЫН СИСТЕМД:
- БУХ НАСОС СТАНЦУУД
 - ДАХИН ДАМЖУУЛАХ ӨРГӨТГӨЛИЙН СТАНЦУУД
 - УСАН САНГУУД
 - ТҮГЭЭХ ШУГАМЫН ЗОХИЦУУЛАХ ХААЛТАЙ ХЯНАЛТЫН 70 ГАРУЙ ЦЭГ

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ШИНЭЧЛЭЛТ УГСРАЛТ

ДАРГАЛТЫН ХЯНАЛТЫН ХУДАГ	10 ширхэг
ЗАРДАЛ ХЯНАЛТЫН ХУДАГ	10 ширхэг
ТООЛУУР ХЯНАЛТЫН ХУДАГ	10 ширхэг

ҮЙЛДВЭРИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН НАСОС СТАНЦ

630 кВт-ЫН НАСОС	4 ширхэг
ГҮНИЙ ХУДГИЙН НАСОС	16 ширхэг
250 кВт-ЫН ДАВТАМЖ ХУВИРГАГЧ	1 ширхэг

ТӨВИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН НАСОС СТАНЦ

ӨРГӨТГӨЛИЙН БАРИЛГА	1 ширхэг
600 кВт-ЫН ДАВТАМЖ ХУВИРГАГЧ	1 ширхэг

ДЭЭД ЭХ ҮҮСВЭРИЙН НАСОС СТАНЦ

6000 вольтын ДАВТАМЖ ХУВИРГАГЧ	1 ширхэг
--------------------------------	----------

ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ

РЕЗЕРВУАРЫН БАРИЛГА	10'000 ширхэг
АЭРОТАНКИЙН БЕТОН ХИЙЦИЙН ШИНЭЧЛЭЛ	6 ширхэг
АГААРЫН ДИФУЗОР	20 ширхэг
ЦАХИЛГААН ХААЛТ	5 ширхэг
УУССАН ХҮЧИЛТӨРӨГЧ МЭДРЭГЧ	
СЕЛЕКТОР	


02. ҮЙЛДВЭРИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН НАСОС СТАНЦ



03. ТӨВ ЭХ ҮҮСВЭРИЙН НАСОС СТАНЦ



01. ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ



ХӨТӨЛБӨРИЙН 2 ДУГААР ҮЕ ШАТНЫ ХҮРЭЭНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭНҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ

2024.12.31-ны байдлаар

№	Багцын дугаар	Ажлын нэр	Гэрээ байгуулсан дүн	Гэрээний хугацаа		Барилгын ажлын явц	Санхүүжилтийн явц
				Эхлэх	Дуусах		
Бүрэлдэхүүн 1			192,109.43				
	АХБ-ны зээл		148,509.42				
1	BHF06B	Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаан хангамжид холбох, дулааны даралт өргөх, насос станц, ус дулаан дамжуулах төв, дулааны шинэ шугамын зураг төсөл, ханган нийлүүлэлт, угсралтын ажил	20,533.49	10/12/2018	7/30/2021	100.00%	100.00%
2	GWD14	Сэлбийн хөрсний ус зайлуулах 2,2 км шугамын ажил	1,819.72	9/30/2019	1/30/2020	100.00%	100.00%
3	GWD11	Сэлбийн хөрсний ус зайлуулах 1,3 км шугамын ажил	3,593.25	9/30/2019	1/30/2020	100.00%	100.00%
4	DARI 1	Дамбадаржаа дэд төв орчмын дэд бүтцийн барилга угсралтын ажил	23,047.94	12/15/2022	7/31/2025	61.82%	41.14%
5	DARI 2	Дамбадаржаа дэд төв орчмын дэд бүтцийн барилга угсралтын ажил	19,489.73	12/15/2022	7/31/2025	57.28%	30.00%
6	DAHP	Дамбадаржаа дулааны станц	80,026.28	8/14/2023	2/07/2025	6.83%	20.00%
	ЕХОБ-ны санхүүжилт		43,600.00				
7	WSC16B	Шархад дэд төвийн Цайз эко хотхон хорооллыг төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын шугам, халуун, дулааны шугам, болон цахилгаан хангамжийн шугамд холбох зураг төсөл, ханган нийлүүлэлт, угсралтын ажил	6,076.00	5/22/2020	11/14/2021	100.00%	100.00%
8	HSSC-A1	Шинэ суурьшлын бүсэд хийгдэх сайжруулсан нүхэн жорлон суурилуулах	234.71	10/1/2020	10/30/2021	100.00%	98.44%
9	HSSC-A2	Шинэ суурьшлын бүсэд хийгдэх сайжруулсан нүхэн жорлон суурилуулах	178.12	11/14/2022	6/1/2023	100.00%	90.00%
10	DAEC	Дамбадаржаа дэд төв орчмын дэд бүтцийн барилга угсралтын ажил	6,055.01	8/14/2023	2/14/2025	49.69%	10%
11	HSSC-B	2-р хэлхээний дулаан хангамж, хэрэгцээний халуун ус, цэвэр усны шугам сүлжээний угсралтын ажил	1,908.99	10/1/2020	9/2/2021	100.00%	100.00%

№	Багцын дугаар	Ажлын нэр	Гэрээ байгуулсан дүн	Гэрээний хугацаа		Барилгын ажлын явц	Санхүүжилтийн явц
				Эхлэх	Дуусах		
12	USF	Морингийн даваа орчмын шинэ суурьшлийн бүсийг инженерийн хангамжийн шугам сүлжээнд холбох	14,343.95	10/23/2020	3/30/2024	100.00%	96.95%
13	HSSC-C	Баянхошуу дэд төвийн нийгмийн байгууламжийн усан хангамж, ариутгах татуурга, ахуйн хэрэглээний халуун ус, дулааны шугам сүлжээ, цахилгааны холболтын угсралтын ажил	3,878.88	10/25/2020	12/31/2024	91.30%	91%
14	HSSC-D	сэлбэ дэд төвийн 2-р хэлхээний инженерийн шугам сүлжээний угсралтын ажил	2,178.50	1/10/2022	10/7/2022	100.00%	98.51%
15	DAFPE	Дамбадаржаа дэд төв орчмын үерийн хамгаалалтын далан угсралтын ажил	2,730.01	4/11/2022	12/31/2024	100.00%	95.00%
16	WSWWPDA	Дамбадаржаа дэд төвийн усан хангамж, бохир усны хоолой, тоног төхөөрөмж нийлүүлэх ажил	1,281.71	10/26/2021	12/31/2024	100.00%	87.40%
17	SHSTC-A	Сонгинохайрхан дүүрэг 1, 2, 20-р хороо, Цэргийн хотхон орон сууцны хороолол орчмын Б хэсэгчилсэн талбай дахь гадна дулаан хангамжийн инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил	4,734.94	9/11/2023	11/30/2025	43.60%	51.00%
Бүрэлдэхүүн 2			45,889.47				
	АХБ-ны зээл		40,137.94				
18	SHS	Нүүлгэн шилжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх 126 айлын түрээсийн орон сууц	14,146.28	11/18/2020	5/30/2024	100.00%	96.38%
19	ASKG-BKH	Баянхошуу дэд төвийн 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга	3,999.71	9/2/2021	11/17/2023	17.25%	20.8%
20	DDCD-BKH	Баянхошуу дэд төвийн Олон нийтийн хөгжлийн төвийн барилга	2,940.92	2/25/2021	12/4/2023	28.00%	18.15%
21	DDPK-BKH	Баянхошуу дэд төвийн Баянхошуу хайрхан дээрх цэцэрлэгт хүрээлэн	2,385.25	1/3/2021	10/31/2024	85.00%	81.00%
22	BDSC-BKH	Баянхошуу дэд төвийн спорт цогцолборын барилгын ажил	16,665.78	9/28/2021	12/31/2024	74.50%	45.09%
	ЕХОБ-ны санхүүжилт		5,751.53				
23	ASKG-DA	Дамбадаржаа дэд төвд баригдах 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын барилга угсралтын ажил	5,751.53	7/11/2023	2/7/2025	57.93%	22.00%
Бүрэлдэхүүн 3			49,164.16				

№	Багцын дугаар	Ажлын нэр	Гэрээ байгуулсан дүн	Гэрээний хугацаа		Барилгын ажлын явц	Санхүүжилтийн явц
				Эхлэх	Дуусах		
24	VSI lot1	Талбайн хяналтаар явахад хэрэглэх машин /3ш/ худалдан авах	264.00	3/25/2021	6/26/2021	100.00%	100.00%
25	LAE	Газрын албаны тоног төхөөрөмж	265.73	3/23/2020	5/11/2020	100.00%	100.00%
26	T2-CS01	Инженерийн зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ	17,080.53	11/16/2018	12/31/2025	82.00%	65.00%
27	T2-CS02	Төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж чадавх бэхжүүлэх зөвлөх үйлчилгээ	20,390.91	1/4/2019	12/31/2024	95.00%	91.84%
28	T2-CS03	Байгаль орчны хөндлөнгийн хяналт хийх зөвлөх үйлчилгээ	372.74	3/11/2021	11/30/2026	58.00%	65.23%
29	T2-CS05	Төсөл 3-ын Инженерийн нарийвчилсан зураг төсөл болон барилга угсралтын ажлын хяналт хийх зөвлөх үйлчилгээ	10,160.24	12/25/2020	12/31/2025	47.00%	57.6%
30	DS-SHS	Зураг төсөл зохиогчийн хяналт хийх зөвлөх үйлчилгээ (Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороо, Ханын материал орчимд баригдах 9 давхар, 2 блок, нийт 126 айлын түрээсийн орон сууцны барилга угсралтын ажил)	90.00	10/28/2021	10/30/2023	100.00%	100.00%
Нийт			287,163.06				

ХӨТӨЛБӨРИЙН 2 ДУГААР ҮЕ ШАТНЫ ХҮРЭЭНД БАЙГУУЛСАН БАРИЛГЫН АЖЛЫН ЯВЦ

Баянхошуу дэд төв

**II ҮЕ ШАТ. БАЯНХОШУУ ДЭД ТӨВ
НИЙГМИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ****БУА үргэлжилж байгаа**

- 1 Цэцэрлэгт хүрээлэн
- 2 126 айлын түрээслээд өмчлөх орон сууц
- 3 650 хүний суудалтай спорт цогцолбор
- 4 200 хүнд үйлчлэх олон нийтийн хөгжлийн төвийн барилга
- 5 Аврах, гал унтраах 2Ф ангийн барилга



SHS - 126 айлын орон сууцны барилга

Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороо, Ханын материал орчимд баригдах 9 давхар, 2 блок, нийт 126 айлын түрээсийн орон сууцны барилга угсралтын ажил



Гүйцэтгэгч: Монкон Констракшн ХХК



DDPK-ВКН: Баянхошуу дэд төвд баригдах цэцэрлэгт хүрээлэнгийн барилга угсралтын ажил


Авто зогсоол, Дугуйн зам, Явган зам, Хөл бөмбөгийн талбай, Сагсан бөмбөгийн талбай, Хүүхдийн тоглоомын талбай, Усан толио, Түргэн үйлчилгээний цэгийн барилгууд, Цагдаагийн байр, Нийтийн бие засах газар, сүүдрэвч, дугуйн зогсоол бүхий 2 га талбайн тохижилт



Гүйцэтгэгч: Дүүрэн трейд ХХК



DDCD-BKH: Баянхошуу дэд төвд баригдах "Олон нийтийн хөгжлийн төв"-ийн барилга угсралтын ажил



Гүйцэтгэгч: Тэш Агь Констракшн ХХК болон Ай Ди Си Проперти ХХК-ын түншлэл



BDSC-BKH: Баянхошуу дэд төвд баригдах спорт цогцолборын барилга угсралтын ажил



Гүйцэтгэгч: Стандарт Холдинг ХХК, Би анд Би Констракшн ХХК болон Таний зам ХХК-ын түншлэл



ASKG-BKH; Баянхошуу дэд төвд баригдах цэцэрлэгийн барилга угсралтын ажил



Гүйцэтгэгч: Цаст Констракшн ХХК



HSSC-C: Баянхошуу дэд төвийн үе шат 2-н хүрээнд баригдах нийгмийн барилга байгууламжийг төвийн шугам сүлжээнд холбох

- Дулааны шугам, 2*1.7км
- Усан хангамжийн шугам, 2.4км,
- Ариутгах татуургын шугам, 0.3км
- Ус дулаан дамжуулах төвийн барилга

Гүйцэтгэгч: “Эс энд Ай Трейд” ХХК



ХӨТӨЛБӨРИЙН 2 ДУГААР ҮЕ ШАТНЫ ХҮРЭЭНД БАЙГУУЛСАН БАРИЛГЫН АЖЛЫН ЯВЦ

ДАМБАДАРЖАА ДЭД ТӨВ

70.7 га

төслийн
ТАЛБАЙ



1

ДУЛААНЫ
СТАНЦ
63МВТ



2

МЭДЭЭЛЭЛ
ХОЛБООНЫ
БАРИЛГА



3


150 ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГ

1'973

ТӨЛӨВЛӨСӨН
ОРОН СУУЦ

7'105

ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХҮН АМ



авто замын сүлжээ

Авто зам

2.8 км

дулаан хангамж

УДДТ

дулааны шугам

4 ширхэг

2.6 км

ус хангамж, ариутгах татуурга

цэвэр усны шугам

2.3 км

ариутгах татуургын шугам

3.0 км

цахилгаан хангамж, мэдээлэл холбоо

цахилгааны кабель шугам

2.1 км

хаалттай дэд өртөө (ХТП)

2 ширхэг

хуваарилах байгууламж (РП)

1 ширхэг

холбооны шугам

1.5 км

Шилэн кабель

4.8 км

ТОХИЖИЛТ

үерийн хамгаалалтын суваг

1.7 км

хөрсний ус зайлуулах шугам

1.6 км

ногоон байгууламж

-

нийгмийн байгууламж

Дулааны станц 63 МВт

1 ширхэг

Мэдээлэл холбооны барилга

1 ширхэг

Бизнес инкубатор төв

-

150 хүүхдийн цэцэрлэг

1 ширхэг

640 хүүхдийн сургууль

-

Эрүүл мэндийн төв


-

DAFPE: Дамбадаржаа дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн ажил


Гүйцэтгэгч: Ньюконстракшн ХХК болон Тэнүүн Хас ХХК-ны түншлэл

- ❖ **БАЙРШИЛ:** СҮХБААТАР ДҮҮРГИЙН 16, 17-Р ХОРОО
- ❖ **БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ:** 2022.05.20-2023.12.31

- | | |
|--|-------------|
| ✓ Үерийн хамгаалалтын суваг-1: | 569м |
| ✓ Үерийн хамгаалалтын суваг-2: | 236м |
| ✓ Ус хүлээн авах худаг: | 32ш |
| ✓ Авто замын борооны ус зайлуулах Ф300 ийн хоолой: | 6ш |
| ✓ Шүүрт худаг: | 854м |
| | 32ш |



DARI1&2: Дамбадаржаа дэд төв орчмын дэд бүтцийн барилга угсралтын ажил



Гүйцэтгэгч: Янченг Шинггуо Констракшн Инженеринг ХХК



Хөрсний ус зайлуулах шугам 95%



Дулааны шугам 70%




Цэвэр усны шугам 40%



УДДТ-ийн барилга 70%



Авто замын ажил 23%



ASKG-DA: Дамбадаржаа дэд төвд баригдах 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын барилга угсралтын ажил



Гүйцэтгэгч: Голомт Констракшн ХХК, Ти Энд Жи ХХК болон Ноён Сайхан ХХК-иудын түншлэл



ДЭД ТӨВТЭЙ УЯЛДАА ХОЛБООТОЙ АЖЛУУД

USF: Шинэ суурьшлын бүсэд баригдах үндсэн дэд бүтэц, шугам сүлжээний ажил

Гүйцэтгэгч: Набсан ХХК, ЧММ ХХК болон Санжат ХХК -ын түншлэл

- ❖ **БАЙРШИЛ:** ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 10-Р ХОРОО
- ❖ **БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ:** 2021.04.20-2023.12.31



МОРИНГИЙН ДАВААНД ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН ДЭД БҮТЦИЙН АЖЛУУД:

- ✓ Гадна цэвэр усны шугам 11,2км
- ✓ Гадна бохир усны шугам 4,25км
- ✓ Гадна холбооны шугам 3.9км
- ✓ Гадна цахилгааны шугам 25,7км
- ✓ Хуваарилах байгууламжийн барилга 1
- ✓ Усан сангийн барилга 1
- ✓ Усан сангийн харуулын барилга 1
- ✓ Усан сангийн орц гарц авто зам 86m
- ✓ Бохир усны насос станц 2
- ✓ Насос станцын харуулын барилга 2



ХӨТӨЛБӨРИЙН 2 ДУГААР ҮЕ ШАТНЫ ХҮРЭЭНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭНҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ

2024.12.31-ны байдлаар

№	Багцын дугаар	Ажлын нэр	Гэрээ байгуулсан дүн	Гэрээний хугацаа		Барилгын ажлын явц	Санхүүжилтийн явц
				Эхлэх	Дуусах		
Бүрэлдэхүүн 1			38,218.26				
			619.02				
1	SC-A	Барилгын талбарын байгаль орчны ариутгал, халдваргүйжүүлэлт, хог хаягдлыг цэвэрлэх тээвэрлэх, нөхөн сэргээлт хийх 1-р хэсгийн ажил	309.52	12/12/2022	6/1/2023	100.00%	100.00%
2	SC-B	Дэд төвүүдийн талбайн цэвэрлэгээ ариутгал хийх ажил (үе шат 2)	309.52	7/17/2023	8/30/2023	100.00%	100.00%
	ЕХОБ-ны санхүүжилт		37,599.24				
3	SHTSC	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй сургууль цэцэрлэгүүдийн дэд бүтцийг бие даасан дэвшилтэт технологиор шийдвэрлэх ажил	6,552.45	6/13/2022	06/30/2025	90%	82.87%
4	TFP	Толгойт дэд төвийн үерийн хамгаалалтын барилга байгууламж	6,548.47	3/30/2021	9/01/2024	90.45%	81.73%
5	TRDH11-C	Толгойт дэд төвийн усан хангамжийн ажил	6,499.46	5/23/2023	07/01/2025	81.11%	35.90%
6	TFP-A	Толгойт дэд төвийн үерийн хамгаалалтын барилга байгууламж	10,148.86	08/07/2023	12/31/2024	37.17%	32.00%
7	SHTSC-B	Сонгинохайрхан дүүргийн 23 дугаар хороо ГХДТ-2019-1 багцын орон сууцны “Оргил” төслийн гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил	6,941.56	09/11/2023	12/31/2025	33.26%	10.00%
8	SHTSC-C	Сэлбэ дэд төвийн бохирын гол коллекторын шугам хоолойн шинэчлэл, засварын угсралтын ажил	908.43	12/12/2023	07/01/2025	80.60%	46.48%
Бүрэлдэхүүн 2			36,248.50				

9	TBC	Толгойт дэд төвд сургалтын төв барилгын угсралтын ажил	5,403.69	7/8/2022	05/30/2025	80.9%	70.53%
10	FSBKH	Гал унтраах, аврах 29 дүгээр ангийн барилга угсралтын ажил	7,934.41	9/8/2022	09/01/2024	55.55%	21.37%
11	SFS	гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалах байрны өарилга угсралтын ажил	8,180.50	11/14/2022	12/31/2024	83.90%	40.31%
12	TSC	640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга угсралтын гэрээ	14,729.89	05/06/2024	12/06/2025	36.32%	0.00%
Бүрэлдэхүүн 3			7,147.58				
13	T3-CS01	Дэд төвийг хөгжүүлэх байгууллагын чадавхыг хөгжүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээ	7,347.27	12/12/2022	30/06/2024	100.00%	84.00%
14	T3-CS02	Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн хөндлөнгийн хяналт шинжилгээ хийх зөвлөх үйлчилгээ	946.14	5/5/2021	12/01/2026	45.50%	59.84%
15	T3-CS03	Байгаль орчны хөндлөнгийн хяналт шинжилгээ хийх зөвлөх үйлчилгээ	661.25	6/20/2022	11/30/2026	54.00%	60.73%
16	DS-SHTSC-B-HS	SHTSC-B-HS багцын зураг төслийн авторын хяналтын гэрээ	45.86	6/14/2024	12/31/2025		0.00%
17	DS-SHTSC-B-WS	SHTSC-B-WS багцын зураг төслийн авторын хяналтын гэрээ	21.91	5/07/2024	12/31/2025		
18	DS-SHTSC-C	SHTSC-C багцын зураг төслийн авторын хяналтын гэрээ	8.8	5/07/2024	07/01/2025		
19	DS-SHTSC-A	SHTSC-A багцын зураг төслийн авторын хяналтын гэрээ	30.90	5/07/2024	11/30/2025		50%
Нийт			81,614.35				

ХӨТӨЛБӨРИЙН 3 ДУГААР ҮЕ ШАТНЫ ХҮРЭЭНД БАЙГУУЛСАН БАРИЛГЫН АЖЛЫН ЯВЦ

ТОЛГОЙТ ДЭД ТӨВ



БИЗНЕС ИНКУБАТОР



640 ХҮҮХДИЙН СУРГУУЛЬ




ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ



ТОХИЖИЛТ 0.9 ГА



ГАДНА ТОХИЖИЛТ



138 га

төслийн
ТАЛБАЙ

21'105

төлөвлөлтийн
ХҮН АМ

5'276

төлөвлөсөн
ОРОН СУУЦ

01. АВТО ЗАМЫН СУЛЖЭЭ

АВТО ЗАМ

6.2 км

02. ТОХИЖИЛТ

ҮЕРИЙН ХАМГААЛАЛТЫН СУВАГ
НОГООН БАЙГУУЛАМЖ

5.9 км

5.94 га

03. ДУЛААН ХАНГАМЖ

ДУЛААНЫ ШУГАМ
УС ДУЛААН ДАМЖУУЛАХ ТӨВ

6.8 км

5 ширхэг

04. УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГА

ЦЭВЭР УСНЫ ШУГАМ
АРИУТГАХ ТАТУУРГЫН ШУГАМ

8.9 км

10.8 км

05. ЦАХИЛГААН ХАНГАМЖ, МЭДЭЭЛЭЛ ХОЛБОО

ЦАХИЛГААНЫ КАБЕЛЬ ШУГАМ
ХААЛТТАЙ ДЭД ӨРТӨӨ (ХТП)
ХУВААРИЛАХ БАЙГУУЛАМЖ (РП)
ХОЛБООНЫ ШУГАМ
ШИЛЭН КАБЕЛЬ

56.4 км

10 ширхэг

2 ширхэг

6.7 км

5.3 км

— одоо байгаа авто зам
— төлөвлөж буй авто зам
— цэвэр усны шугам
— ариутгах татуургын шугам
— дулааны шугам
— холбооны шугам

5 УДДТ
цахилгааны кабель шугам
ХТП
РП
үерийн хамгаалалтын суваг

Толгойт дэд төвийн Сургалтын төвийн барилга



Гүйцэтгэгч: Мандалт констракшн ХХК болон Алтайн Бумбат
Өргөө ХХК-иудын түншлэл



Толгойт дэд төвийн үерийн хамгаалалтын суваг



Гүйцэтгэгч: Монгол менежмент төв ХХК болон Улаанбаатар
менежмент ХХК-иудын түншлэл



**Толгойт дэд төв, Ерөнхий боловсролын 42 дугаар сургуулийн
өргөтгөлийн барилга**



Гүйцэтгэгч: Вайт Финикс ХХК



Толгойт дэд төвийн ус хангамжийн шугам сүлжээний ажил



**Гүйцэтгэгч: “И Жи Өү” ХХК болон НАБСАН ХХК-иудын
түншлэл**



Толгойт дэд төвийн үерийн хамгаалалтын суваг /Баруун наран/



Гүйцэтгэгч: Монгол менежмент төв ХХК



ДЭД ТӨВТЭЙ УЯЛДАА ХОЛБООТОЙ АЖЛУУД

FSBKH: Баянхошуу дэд төвд баригдах гал унтраах, аврах станцын барилга байгууламж

Гүйцэтгэгч: Энигма констракшн ХХК



SFS: Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах байр

Гүйцэтгэгч: Аглут ХХК



SHTSC: Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн Сургууль, цэцэрлэгийн дэд бүтцийг бие даасан дэвшилтэт технологиор шийдвэрлэх ажил

Гүйцэтгэгч: Энержи конвертэр ХХК болон Термомастер ХХК

№	ТӨСӨЛД ХАМРАГДАЖ БУЙ СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГҮҮД	ХИЙГДСЭН АЖИЛ
1.	Сонгинохайрхан дүүргийн 24 дүгээр хороо, 134 дүгээр сургууль	Цахилгаан халаалтын тогоо – 5ш, Хийн түлшний халаалтын зуух – 3ш Ус цэвэршүүлэх төхөөрөмж – 1ком Дизель генератор – 1ком
2.	Сонгинохайрхан дүүргийн 4-р хороо 640 хүүхдийн суудалтай 162-р сургууль	Цахилгаан халаалтын тогоо – 5ш, Хийн түлшний халаалтын зуух – 3ш Ус цэвэршүүлэх төхөөрөмж – 1ком Дизель генератор – 1ком
3.	Сонгинохайрхан дүүргийн 25 дугаар хороо, 104 дүгээр сургууль	Цахилгаан халаалтын тогоо – 8ш, Хийн түлшний халаалтын зуух – 3ш Ус цэвэршүүлэх төхөөрөмж – 1ком Дизель генератор – 1ком
4.	Сонгинохайрхан дүүргийн 25 дугаар хороо, 170 дугаар цэцэрлэг	Цахилгаан халаалтын тогоо – 5ш, Хийн түлшний халаалтын зуух – 3ш Ус цэвэршүүлэх төхөөрөмж – 1ком Дизель генератор – 1ком
5.	Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо, 79 дүгээр сургуулийн 1 дүгээр байр	Цахилгаан халаалтын тогоо – 5ш, Хийн түлшний халаалтын зуух – 3ш Ус цэвэршүүлэх төхөөрөмж – 1ком Дизель генератор – 1ком
6.	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо, 126 дугаар сургууль	Цахилгаан халаалтын тогоо – 5ш, Хийн түлшний халаалтын зуух – 3ш Ус цэвэршүүлэх төхөөрөмж – 1ком Дизель генератор – 1ком
7.	Сүхбаатар дүүргийн 17 дугаар хороо, 58 дугаар сургууль	Цахилгаан халаалтын тогоо – 5ш, Хийн түлшний халаалтын зуух – 3ш Ус цэвэршүүлэх төхөөрөмж – 1ком Дизель генератор – 1ком
8.	Сүхбаатар дүүргийн 18 дугаар хороо, 71 дүгээр сургууль	Цахилгаан халаалтын тогоо – 5ш, Хийн түлшний халаалтын зуух – 3ш Ус цэвэршүүлэх төхөөрөмж – 1ком Дизель генератор – 1ком